

Сангийн сайдын 2020 оны дугаар
сарын-ний өдрийн дүгээр тушаалын
хавсралт

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

БАРАА ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕРИЙН ЖИШИГ БАРИМТ БИЧИГ

Тендерийн баримт бичиг бэлтгэх санамж

Захиалагч тендерийн баримт бичигт энэхүү санамжийг тусгахгүй.

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулахдаа харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгөөс давсан бараа (цаашид “Бараа” гэх) худалдан авах тендерийн баримт бичгийг боловсруулах, батлахдаа энэхүү жишиг баримт бичгийг ашиглана.

Тендерийн баримт бичиг бэлтгэж буй этгээд нь тендерийн жишиг баримт бичгийн тендерийн өгөгдлийн хүснэгт (цаашид “ТӨХ” гэх)-ийг холбогдох заалтуудад зарчмын бус өөрчлөлт оруулах замаар тухайн барааны тендер шалгаруулалтад тавигдах шаардлагад нийцүүлнэ. Эдгээр өөрчлөлтийг хийхдээ дараах удирдамжийг дагаж мөрдөнө. Үүнд:

1. Тендерийн баримт бичгийг худалдан авах барааны онцлог байдалд нийцүүлэн энэхүү жишиг баримт бичгийн дагуу бэлтгэнэ.
2. Хаалт дотор бичсэн жишээ, зааврын оронд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ зэргийг бөглөнө. Тендерт оролцогчийн бөглөх маягыг захиалагч бөглөхгүй.
3. Аль нэг нөхцөлийг хэд хэдэн бүлэг, зүйлд давхар заах шаардлагатай бол тэдгээр нь хоорондоо зөрчилдөхгүй байх ёстойг анхаарвал зохино.
4. Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах ажиллагаа зохион байгуулахаас бусад тохиолдолд тендер шалгаруулалтын зааварчилгаанд заасан “Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах чанар ба үнэлгээний арга”-ыг хасна.
5. Хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.1 дэх заалтад заасан нөхцөл үүсвэл тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлтийг оруулна.
6. Хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.2 дахь заалтад заасан нөхцөл үүсвэл худалдан авах барааны тоо хэмжээ, цар хүрээтэй холбоотой өөрчлөлтийг тендерийн баримт бичигт оруулна.

Энэхүү тендерийн жишиг баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбогдоно уу.

Сангийн яамны Хууль эрх зүйн газар

Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтэс

Утас: 260206, 267416, 267648

Худалдан авах ажиллагааны цахим систем: www.tender.gov.mn

АГУУЛГА

Бүлэг I. Тендерт шалгаруулалтын зааварчилгаа (ТШЗ)

Энэ бүлэг нь тендер бэлтгэх, илгээх, нээх, үнэлж шалгаруулах болон гэрээ байгуулах эрх олгохтой холбоотой мэдээллийг тендерт оролцогчид өгнө. Мөн “хамгийн сайн” тендерийг шалгаруулах үнэлгээний шалгуур үзүүлэлт, аргачлал болон тендерт оролцогч тухайн гэрээг гүйцэтгэх чадвартай эсэхийг тогтоох ерөнхий шалгуур үзүүлэлтийг ТШЗ-д дурдсан байна. Нэгдүгээр бүлэг дэх зүйл, заалтуудыг захиалагч өөрчлөхгүйгээр ашиглана. Энэ бүлэгт тусгагдсан зааварчилгааг захиалагч, тендерт оролцогч өөрчлөхгүйгээр ашиглах бөгөөд тавигдах шаардлага, бүрдүүлэх материалыг тендерт оролцогч бүрэн хангасан байна. Хоёрдугаар бүлгийн зүйл, заалттай зөрчилдвөл хоёрдугаар бүлгийн мэдээллийг баримтална.

Бүлэг II. Тендерийн өгөгдлийн хүснэгт (ТӨХ)

Захиалагч шаардлагад нийцсэн тендер хүлээж авахад шаардлагатай мэдээллийг энэ бүлэгт тусгана.

Худалдан авах барааны талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендер шалгаруулалтын зааварчилгаа (ТШЗ)-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Тендерт оролцогч нэгдүгээр бүлгийн ТШЗ-ны зүйл, заалт болон уг бүлэгт заасан мэдээллийг баримтлан тендер бэлтгэнэ.

Тухайн шалгуур үзүүлэлтийг холбогдох бусад салбарын хууль тогтоомжийн хүрээнд хангаж буй тохиолдолд уг бүлэгт тэдгээр шалгуурыг тусгах шаардлагагүй. *Тухайлбал,*

- *Аудитын тухай хуульд санхүүгийн тайланд заавал аудит хийлгэх аж ахуйн нэгж, байгууллагыг заасан байдаг тул бүх тендер шалгаруулалтын хувьд аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг заавал шаардах шаардлагагүй;*
- *Заавал гэрчлүүлэх нотариатын үйлдлийг зөвхөн хуулиар тогтоох бөгөөд үүнээс бусад үйлдлийг үйлчлүүлэгчийн хүсэлтээр гэрчлэхээр заасан байдаг тул тендерийн бүх баримт бичгийг нотариатаар заавал гэрчлүүлсэн байхыг шаардах шаардлагагүй;*

Тендерт оролцогчид нэмэлт тавигдах шаардлага болон бүрдүүлэх материалыг энэ бүлэгт тусгайлан заах бөгөөд тусгайлан заагаагүй тохиолдолд нэгдүгээр бүлгийн зааварчилгааг баримтална.

Бүлэг III. Тендерийн жишиг маягт

Энэ бүлэгт тендер илгээх маягт, үнийн хуваарийн хүснэгт, тендерийн баталгааны маягт болон нийлүүлэх хуваарийн маягт зэрэг тендерт оролцогчоос өөрийн тендерийн хамт бөглөж ирүүлэх шаардлагатай маягтууд багтана.

Бүлэг IV. Техникийн тодорхойлолт болон бусад шаардлага

Энэ бүлэгт худалдан авах бараа болон түүнийг дагалдах үйлчилгээний жагсаалт, тэдгээрийг захиалагчид хүргэх хуваарь, техникийн тодорхойлолт болон дагалдах үйлчилгээг тайлбарласан, дүрсэлсэн зураг зэрэг мэдээлэл багтана.

Жич: Энэхүү тендерийн жишиг баримт бичгийн хэсэг, бүлгийн оноосон нэр, гарчиг нь уг баримт бичгийг ойлгоход хялбар дөхөм болгох зорилгоор хэрэглэсэн бөгөөд ямар нэгэн хэм хэмжээ илэрхийлэхгүй болохыг анхаарна уу.

[ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГЫН НЭР]

[ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БАТЛАГДСАН НЭР]-ИЙН
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендер
шалгаруулалтын нэр,
дугаар:

.....

АГУУЛГА

БҮЛЭГ I. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА.....	3
А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	3
1. Тендерийн цар хүрээ	3
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг	3
3. Залилан мэхлэх болон авлига, ашиг сонирхлын үйлдэл.....	3
4. Тендер шалгаруулалтад оролцох эрх бүхий этгээд.....	3
5. Туслан гүйцэтгэгч ба түншлэл.....	4
6. Тендерт оролцогч нэг этгээд нэг тендер ирүүлэх	5
7. Нийлүүлэх барааны гарал үүсэл.....	5
Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА.....	5
8. Тендерийн баримт бичиг	5
9. Тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах	6
10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт	6
11. Тендерийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах	7
12. Тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгах	7
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ.....	8
13. Тендер шалгаруулалтад оролцох зардал	8
14. Тендерийн хэл	8
15. Тендерийн иж бүрдэл	8
16. Тендер илгээх маягт ба тендерийн жишиг маягтууд.....	9
17. Хувилбарт тендер.....	9
18. Ерөнхий нөхцөлийг магадлахад шаардлагатай баримт бичиг	9
19. Гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхийг магадлахад шаардлагатай баримт бичиг .	10
20. Санал болгож буй бараа тендерийн баримт бичгийн шаардлагад нийцэж буйг нотлох баримт бичиг	12
21. Тендерийн үнэ болон үнийн хөнгөлөлт	13
22. Тендерийн валют.....	14
23. Тендер хүчинтэй байх хугацаа.....	15
24. Тендерийн баталгаа	15
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ	17
25. Тендер баталгаажуулах, илгээх.....	17
26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа	18
27. Тендерт нэмэлт өөрчлөлт хийх, тендерийг буцааж авах.....	18
28. Тендерийг нээх	18
Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ	19
29. Нууцлах.....	19

30. Тендерийн талаар тайлбар, тодруулга авах	19
31. Тендерийг хянан үзэх, шаардлагад нийцсэн эсэхийг тогтоох	20
32. Тендерийг үнэлэх.....	21
33. Нэг валютад хөрвүүлэх	21
34. Арифметик алдааг залруулах	21
35. Давуу эрх олгох.....	22
36. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох	22
37. Тендерийг харьцуулах.....	23
38. Тендерт оролцогчийн чадварыг дахин магадлах.....	23
39. Захиалагч тендерээс татгалзах	24
Е. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ.....	24
40. Гэрээ байгуулах эрх олгох шалгуур	24
41. Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл	24
42. Тендер шалгаруулалттай холбоотой гомдол	25
43. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах	25
44. Гүйцэтгэлийн баталгаа	25
45. Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдаж буй тендер шалгаруулалт	26
46. Мэдээллийн ил тод байдал.....	26
БҮЛЭГ II. ТЕНДЕРИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ	30
БҮЛЭГ III. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ	35

БҮЛЭГ I. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- | | |
|---|---|
| 1. Тендерийн цар хүрээ | <p>1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулах үүрэг бүхий, тендерийн өгөгдлийн хүснэгт (цаашид “ТӨХ” гэх)-д тодорхойлсон захиалагч нь ТӨХ-д заасан тендерийн урилгыг нийтэлж, энэ тендерийн баримт бичгийн Бүлэг IV-т тодорхойлсон техникийн тодорхойлолт бүхий бараа (цаашид “бараа” гэх)-г худалдан авах зорилгоор энэхүү тендерийн баримт бичгийг гаргаж байна. Энэхүү тендер шалгаруулалтын нэр, дугаарыг ТӨХ-д заасна.</p> <p>1.2. Тендер шалгаруулалт нь ТӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд нэг багцтай байна. Хуулийн 10¹ дүгээр зүйлд заасан чанар, стандартын шаардлага хангасан дотоодын үйлдвэрээс худалдан авах барааг бусад бараанаас тусад нь багцална.</p> <p>1.3. Хэрэв багцалсан бол тендерт оролцогч нэг, эсхүл түүнээс олон багцад тендер ирүүлж болно.</p> |
| 2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг | <p>2.1. Захиалагч тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн төсөвт өртөг болон санхүүжүүлэх эх үүсвэрийг ТӨХ-д бичнэ.</p> |
| 3. Залилан мэхлэх болон авлига, ашиг сонирхлын үйлдэл | <p>3.1. Захиалагчийг төлөөлөн худалдан авах ажиллагаанд оролцож байгаа албан хаагч, хөндлөнгийн этгээд болон тендерт оролцогч, гүйцэтгэгч ёс суртахууны өндөр хэм хэмжээг сахин биелүүлэх ёстой.</p> <p>3.2. Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа албан хаагч, үнэлгээний хорооны гишүүн болон тендерт оролцогч Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан авлига, ашиг сонирхол, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон талаар бодитой мэдээлэл байгаа бол холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хуулийн 50 дугаар зүйлийн нэн даруй зохих ёсоор мэдэгдэх үүрэгтэй.</p> <p>3.3. Энэ зүйлийг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.</p> |
| 4. Тендер шалгаруулалтад оролцох эрх бүхий этгээд | <p>4.1. Тендерийн урилга нь сонирхсон этгээд бүрд нээлттэй. Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн дагуу гадаадын этгээдийг оролцуулахгүйгээс бусад тохиолдолд тендерт оролцогч болон түүний түншлэлийн гишүүн аль ч улсын харьяалалтай байж болно.</p> |

- 4.2. Тендерт оролцогч болон түүний түншлэлийн гишүүд тус тусдаа захиалагчаас хараат бус этгээд байна. Түншлэлийн гишүүдийн тоонд хязгаар тавихгүй.
- 4.3. ТШЗ-ны 1.2-т зааснаар дотоодын үйлдвэрээс худалдан авах барааны багцад гадаадын этгээд дангаар болон түншлэлийн гишүүнээр тендер ирүүлэх, эсхүл Монгол Улсын гарал үүсэлтэй бус бараа нийлүүлэх тендер ирүүлэхийг тус тус хориглоно.
- 5. Туслан гүйцэтгэгч ба түншлэл**
- 5.1. Тендерт оролцогч нэг ба түүнээс дээш тооны хуулийн этгээдтэй туслан гүйцэтгэгчийн гэрээ байгуулж болно.
- 5.2. ТШЗ-ны 5.1-д заасан нийт туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж болох хэмжээ тендерт оролцогчийн санал болгож буй үнийн дүнгийн 10 хувиас хэтрэхгүй.
- 5.3. Тендерт оролцогч ТШЗ-ны 5.2-т зааснаас дээш хувийг бусдаар гүйцэтгүүлэх тохиолдолд ТШЗ-ны 5.4-т заасны дагуу түншлэлээр оролцоно.
- 5.4. Хоёр ба түүнээс дээш тооны хуулийн этгээд хамтран ажиллах гэрээний үндсэн дээр нэг тендерт оролцогч (цаашид талуудыг хамтад нь “түншлэл”, тус бүрийг нь “түншлэлийн гишүүн” гэх) болж тендер ирүүлэх тохиолдолд талууд тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт болон дараах шаардлагыг хангасан түншлэлийн гэрээ байгуулна. Үүнд:
- 5.4.1. Иргэний хуульд заасан хамтран ажиллах гэрээний шаардлага хангасан байх;
- 5.4.2. ТШЗ-ны 1.1-д заасан бараа нийлүүлэхэд түншлэлийн бүх гишүүн хамтран болон тус тусдаа хүлээх хариуцлагыг гэрээнд тодорхойлсон байх;
- 5.4.3. түншлэлийн нэрийн өмнөөс үүрэг хүлээх, зааварчилгаа хүлээн авах болон бусад этгээдтэй харилцахад тэдгээрийг төлөөлөх эрх бүхий нэг гишүүн томилох;
- 5.4.4. нийт гэрээний гүйцэтгэл, түүний дотор төлбөр тооцоог зөвхөн төлөөлөх эрх бүхий гишүүнтэй харилцаж, гүйцэтгэх тухай заасан байх;
- 5.4.5. түншлэлийн гэрээг холбогдох журамд зааснаар цахим системээр дамжуулан байгуулсан байх.
- 5.5. Түншлэлийн гишүүн тус бүр нь ТШЗ-ны 18-д заасан ерөнхий нөхцөлийг хангасан байх ба бараа нийлүүлэхэд өөрийн хариуцах хэсэгт холбогдох тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийг авсан этгээд байна.

- 6. Тендерт оролцогч нэг этгээд нэг тендер ирүүлэх**
- 6.1. Аливаа этгээд дангаараа, эсхүл түншлэлийн гишүүний хувиар тендер шалгаруулалтад оролцохдоо зөвхөн нэг тендер ирүүлнэ. ТШЗ-ны 17-д зөвшөөрснөөр хувилбарт тендер ирүүлсэн нь энэ шаардлагыг зөрчсөнд тооцогдохгүй.
- 6.2. Тендерт оролцогч, түүний түншлэлийн гишүүн нь тендер шалгаруулалтын нэг багцад оролцож байгаа бусад тендерт оролцогч, түүний түншлэлийн гишүүнтэй Өрсөлдөөний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтад заасан харилцан хамааралтай, эсхүл тэдгээрийн итгэмжлэлээр болон итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд нь нэг этгээд бол ТШЗ-ны 6.1-д заасныг зөрчсөн гэж үзнэ.
- 7. Нийлүүлэх барааны гарал үүсэл**
- 7.1. Хуулийн 10¹ дүгээр зүйлд заасан чанар, стандартын шаардлага хангасан, дотоодын үйлдвэрээс худалдан авах барааны багцад санал болгохоос бусад тохиолдолд гэрээгээр нийлүүлэх бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно.
- 7.2. Хуулийн 10¹ дүгээр зүйлийн дагуу нийлүүлэгдэх бараа нь хуульд заасан Монгол Улсын гарал үүсэлтэй барааны шалгуурыг хангасан байна.

Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА

- 8. Тендерийн баримт бичиг**
- 8.1. Захиалагч тендерийн баримт бичгийг худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/ (цаашид “цахим систем” гэх)-ээр дамжуулан олон нийтэд нээлттэй байршуулна.
- 8.2. ТШЗ-ны 8.1-д заасны дагуу цахим системд байршуулсан тендерийн баримт бичиг нь доорх бүлгүүд болон ТШЗ-ны 11-д зааснаар түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ.
- Бүлэг I. Тендер шалгаруулалтын зааварчилгаа
Бүлэг II. Тендерийн өгөгдлийн хүснэгт
Бүлэг III. Тендерийн жишиг маягт
Бүлэг IV. Техникийн тодорхойлолт
- 8.3. Захиалагч ТШЗ-ны 8.1-д заасан тендерийн баримт бичигтэй нийцүүлэн тендерийн урилгыг боловсруулж, Хууль болон журамд зааснаар цахим систем болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.
- 8.4. Тендерт оролцогч болон тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээд нь тендерийн баримт бичиг дэх бүх зааварчилгаа, тендерт оролцогчид тавигдах шаардлага, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд ишилсэн журам, зааврыг судалж тендерийн баримт бичигт тавигдсан шаардлагын дагуу боловсруулах үүрэгтэй.
- 8.5. Төлбөртэй худалдах тендерийн баримт бичгийн үнийг төлсөн, эсхүл төлбөргүй тараах тендерийн баримт бичгийг цахим системээс татаж авсан этгээд нь тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч

этгээд (цаашид “сонирхогч этгээд”) гэж тооцогдоно.

9. Тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах

- 9.1. Сонирхогч этгээд нь тендерийн баримт бичгийн талаар тодруулга, нэмэлт мэдээлэл авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтээ ТШЗ-ны 9.5-т заасан хугацааны дотор тодруулга, нэмэлт мэдээлэл гаргах ердийн боломжит хугацааны өмнө захиалагчид гаргаж болно.
- 9.2. Сонирхогч этгээд хүсэлтээ ТШЗ-ны 9.1-т зааснаар ердийн боломжит хугацаа буюу ажлын 1-ээс доошгүй хоногийн өмнө гаргаагүй бол хүсэлтийн дагуу заавал тодруулга, нэмэлт мэдээлэл гаргах үүрэг хүлээхгүй.
- 9.3. ТШЗ-ны 9.1-д заасан хүсэлт гаргах албан бичгийг сонирхогч этгээд захиалагчийн ТӨХ-д заасан хаягаар хүргүүлэх ба тендерийн баримт бичгийг худалдан авсан бол энэ тухай баримтыг хавсаргасан байна.
- 9.4. Сонирхогч этгээд нь ТШЗ-ны 9.1-д заасан хүсэлт албан бичгийн хуулбарыг цахим системээр дамжуулан захиалагчид хүргүүлсэн бол ТШЗ-ны 9.2-т зааснаар хүргүүлсэнд тооцно.
- 9.5. Захиалагч ТШЗ-ны 9.1-д заасан хүсэлтийн дагуу гаргах тодруулга, нэмэлт мэдээллийг ТШЗ-ны 26.1-д заасан хугацаанаас ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө гаргана.
- 9.6. Захиалагч нь тендерийн баримт бичгийн тодруулга, нэмэлт мэдээллийг цахим системд холбогдох журмыг баримтлан нийтэлсэн нь Хуульд зааснаар бүх сонирхогч этгээдүүдэд хүргүүлсэнд тооцогдоно.
- 9.7. Тухайн тодруулга, нэмэлт мэдээллийн үр дүнд захиалагч тендерийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ны 12.1-т заасан журмыг баримтална.

10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт

- 10.1. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалтыг зохион байгуулах талаар ТӨХ-д заасан бол сонирхогч этгээдээс томилсон төлөөлөгчийг түүнд урьж оролцуулна. Уг уулзалт нь тендер бэлтгэх явцад үүсэж болох аливаа асуудлыг тодруулах, энэ талаар сонирхогч этгээдийн тавьсан асуултад хариулт өгөх зорилготой.
- 10.2. Тендерийн өмнөх уулзалтад оролцоогүй нь тендер оролцохыг сонирхогч этгээдийн тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарлахгүй.
- 10.3. Захиалагч болон үнэлгээний хорооны гишүүд нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш болон гэрээ байгуулах эрх олгохоос өмнө тендер оролцогч, түүний төлөөлөгчтэй ямар нэгэн уулзалт зохион байгуулахгүй.

- 11. Тендерийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах**
- 11.1. Захиалагч ТШЗ-ны 26.1-д заасан хугацаа дуусахаас өмнө тендерийн баримт бичигт захиалагч тендерийн баримт бичгийг баталсан хэлбэрээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 11.2. Тендерийн баримт бичгийн аливаа нэмэлт, өөрчлөлт нь түүний салшгүй хэсэг болох бөгөөд цахим системд холбогдох журмын дагуу нийтэлснээр сонирхогч этгээдүүдэд хүргүүлсэнд тооцно.
- 12. Тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгах**
- 12.1. Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгахдаа тендерийн баримт бичгийн холбогдох хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах ба дараах тохиолдолд ТШЗ-ны 26.1-д заасан тендер хүлээн авах эцсийн хугацааг заавал сунгана:
- 12.1.1. Тендерийн баримт бичигт орсон нэмэлт, өөрчлөлтийн улмаас тендер зайлшгүй өөрчлөгдөх ба өөрчлөлтийг бэлтгэхэд шаардагдах хангалттай хугацааг сонирхогч этгээдэд олгох шаардлагатай гэж үзвэл шаардлагатай гэж үзсэн хугацаагаар;
- 12.1.2. ТШЗ-ны 9.1, 9.2-т зааснаар сонирхогч этгээдээс ердийн боломжит хугацаанд ирүүлээгүй хүсэлтийн дагуу захиалагч тодруулга, нэмэлт мэдээлэл гаргах зайлшгүй шаардлагатай гэж захиалагч үзсэн бөгөөд тодруулга, нэмэлт мэдээллийг ТШЗ-ны 9.5-д заасан хугацаанд гаргаагүй бол ийнхүү тодруулга, нэмэлт мэдээлэл хүргүүлснээс хойш ажлын 5-аас доошгүй хоногоор;
- 12.1.3. Захиалагчийн санаачилгаар эсхүл тодруулга, нэмэлт мэдээлийн үр дүнд тендерийн баримт бичигт оруулж буй өөрчлөлт нь хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсгийн дагуу Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын хянавал зохих өрсөлдөөнд сөрөг нөлөө үзүүлэх боломжтой асуудал бол ийнхүү нэмэлт, өөрчлөлт оруулснаас хойш ажлын 14-өөс доошгүй хоногоор.
- 12.2. Тендерийн баримт бичигт оруулж буй дараах нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгахгүй:
- 12.2.1. зөвхөн агуулгын бус, зөв бичих дүрмийн үг, үсгийн алдааг залруулах бол;
- 12.2.2. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын шийдвэрийн дагуу өрсөлдөөнийг дэмжсэн буюу тендерт оролцогчийн тендерийг шаардлага хангаагүй гэж татгалзах үндэслэлийг нэмэгдүүлээгүй нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа бол.

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

- 13. Тендер шалгаруулалтад оролцох зардал**
- 13.1. Тендерт оролцогч болон сонирхогч этгээд тендер бэлтгэх, илгээхтэй холбогдон гарах бүх зардлыг өөрөө бүрэн хариуцах бөгөөд захиалагч ямар ч нөхцөлд тендер шалгаруулалтын явц, үр дүн, хүчинтэй эсэх байдлаас үл хамааран энэхүү зардалтай холбогдох хариуцлага хүлээхгүй.
- 13.2. Сонирхогч этгээд тухайн бараа нийлүүлэх, гэрээний үүрэг гүйцэтгэх газар, орчны нөхцөл байдалтай танилцаж болох бөгөөд түүнтэй холбогдон гарах зардлыг өөрөө хариуцна.
- 14. Тендерийн хэл**
- 14.1. Энэхүү тендерийн баримт бичиг, тендерийн урилгыг гадаад хэл дээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авах бараа нийлүүлэх тендер, түүнчлэн тендер шалгаруулалттай холбоотой асуудлаар захиалагч тендерт оролцогчийн хооронд харилцаж буй албан бичиг, захидлууд болон бусад баримт материал нь монгол хэл дээр байна.
- 14.2. Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр худалдан авах барааны хувьд ТШЗ-ны 14.1-д заасан хэл нь ТӨХ-д заасан хэл байна.
- 14.3. Гадаадын этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхтэй, эсхүл энэхүү тендер шалгаруулалт нь гадаадын этгээдийн сонирхлыг татна гэж үзвэл захиалагч тендерийн баримт бичгийг монгол хэлнээс гадна гадаад хэл дээр бэлтгэнэ. Ийнхүү бэлтгэсэн тендерийн баримт бичиг нь монгол хэл дээрх хувьтай зөрвөл монгол хэл дээр бэлтгэсэн тендерийн баримт бичгийн нөхцөлийг баримтална.
- 14.4. Тендер илгээх маягт, тендерийн аливаа маягт, түүнийг дагалдах баримт бичиг, хэвлэмэл материал нь ТШЗ-ны 14.1-д зааснаас өөр хэл дээр байж болох бөгөөд энэ тохиолдолд тендерт оролцогч нь тэдгээрийн тендерт холбогдох хэсгийг ТШЗ-ны 14.1-д заасан хэл рүү хөрвүүлсэн орчуулгыг ирүүлэх бөгөөд уг орчуулгыг тендерийг хянан үзэх, үнэлэхэд харгалзана.
- 14.5. Тендерт оролцогч нь тендерт ирүүлсэн орчуулгыг өөрөө эсхүл гуравдагч этгээдээр бэлтгүүлсэн эсэхээс үл хамааран орчуулгын үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.
- 15. Тендерийн иж бүрдэл**
- 15.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
- 15.1.1. ТШЗ-ны 16-д зааснаар бэлтгэсэн тендер илгээх маягт;
- 15.1.2. тендер илгээх маягтыг тендерт оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий

- этгээдээс өөр этгээд баталгаажуулсан бол түүнд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотолсон баримт/;
- 15.1.3. захиалагч зөвшөөрсөн бол ТШЗ-ны 17-д зааснаар бэлтгэсэн хувилбарт санал;
- 15.1.4. тендерт оролцогч ерөнхий нөхцөлийг хангасан болохыг нотлох ТШЗ-ны 18-д заасны дагуу хүргүүлэх баримт бичиг;
- 15.1.5. тендерт оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг нотлох зорилгоор ТШЗ-ны 19-д заасны дагуу хүргүүлэх баримт бичгүүд;
- 15.1.6. санал болгож буй бараа нь ТШЗ-ны 7.2-т заасан барааны гарал үүслийг тодорхойлох баримт бичиг;
- 15.1.7. санал болгож буй бараа нь тендерийн баримт бичигт нийцэж буйг баталгаажуулсан ТШЗ-ны 20-д заасны дагуу хүргүүлэх баримт бичиг;
- 15.1.8. ТШЗ-ны 21-д заасны дагуу бэлтгэсэн үнийн хуваарь;
- 15.1.9. захиалагч шаардсан бол ТШЗ-ны 24-д заасны дагуу ирүүлэх тендерийн баталгаа.
- 15.2. Цахим худалдан авах ажиллагаанд тендер илгээх маягтыг цахим системийн холбогдох талбарыг бөглөж илгээж болно.
- 15.3. Түншлэлээр тендер ирүүлэх этгээд нь ТШЗ-ны 15.1-д зааснаас гадна ТШЗ-ны 5.5-д заасан түншлэлийн гэрээг ирүүлэх ба цахим худалдан авах ажиллагааны хувьд түншлэлийн гэрээг цахим системээр дамжуулан баталгаажуулсан байна.
- 16. Тендер илгээх маягт ба тендерийн жишиг маягтууд**
- 16.1. Тендерт оролцогч нь тендер илгээх маягт болон тендерийн бусад маягтыг боловсруулахдаа тендерийн баримт бичгийн Бүлэг III дахь маягтын дагуу бэлдэж ирүүлнэ. Маягтыг бөглөхдөө агуулгад өөрчлөлт оруулахгүй ба холбогдох хэсгийн мэдээллийг нөхөж бөглөнө.
- 17. Хувилбарт тендер**
- 17.1. ТӨХ-д тусгайлан заасан тохиолдолд тендерт оролцогч тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэн саналын хувилбарыг тендерт ирүүлж болно.
- 18. Ерөнхий нөхцөлийг магадлахад шаардлагатай баримт бичиг**
- 18.1. Тендерт оролцогч нь хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасан нөхцөл байхгүй буюу ерөнхий нөхцөлийг хангаж байгаа тухай мэдэгдлийг Бүлэг III дахь тендер илгээх маягтын дагуу ирүүлнэ.
- 18.2. Тендер илгээх маягт дахь мэдэгдлийг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:

- 18.2.1. Гадаадын этгээд нь Монгол Улсын эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрийн өргүй болохыг нотлох баримт;
- 18.2.2. сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасан[, эсхүл авлигын гэмт хэрэгт ял шийтгүүлсэн эсэх] талаар шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр бий эсэх талаар шүүхийн архивын байгууллагаас холбогдох дүрэм, журмын хүрээнд гаргасан тодорхойлолт;
- 18.2.3. Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч хуулийн этгээд нь нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрийн өргүй болохыг нотлох баримт;
- 18.2.4. Шүүхийн шийдвэрээр төлөх төлбөртэй эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт.
- 18.3. Түншлэлээр оролцож байгаа тендерт оролцогчийн гишүүн тус бүр нь ерөнхий нөхцөлийг хангасан байх шаардлагатай тул гишүүн тус бүртэй холбоотой ТШЗ-ны 18.2-т заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлнэ.
- 18.4. Цахим худалдан авах ажиллагаанд оролцож буй Монгол Улсад үүсгэн байуулагдсан хуулийн этгээдийг ерөнхий нөхцөл хангаж байгаа эсэхийг магадлахдаа цахим системд холбогдсон мэдээллийн баазаас дамжуулсан мэдээлэлд үндэслэх тул захиалагч нь тэдгээрийн ерөнхий нөхцөлийг хангаж байгаа эсэхийг магадлах зорилгоор ТШЗ-ны 18.2.2, 18.2.3, 18.2.4-т зааснаас өөр баримт бичиг шаардахгүй.
- 19. Гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхийг магадлахад шаардлагатай баримт бичиг**
- 19.1. Захиалагч нь хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т зааснаар тендер шалгаруулалтад тавигдах санхүүгийн, техникийн чадавхийн болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг тогтоож, тендерийн баримт бичигт тодорхой тусгана.
- 19.2. Захиалагч нь тендерт оролцогчийн санхүүгийн чадавхийг тодорхойлохдоо үндэслэл болгох тайлант хугацааг ТӨХ-д заана.
- 19.3. Тендерт оролцогч нь хуулийн 15 дугаар зүйлд зааснаар гэрээний үүргийн биелэлтийг хангах санхүүгийн чадавхийн талаар ТӨХ-д тавигдсан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичгийг ирүүлнэ.
- 19.4. Санхүүгийн тайландаа аудит хийлгэх хуулийн шаардлага бүхий тендерт оролцогчийг ТШЗ-ны 19.3-т заасан тайлант хугацаанд хамаарах аудитын дүгнэлт ирүүлэхийг ТӨХ-д зааж болно.

- 19.5. Тендерт оролцогчийн санхүүгийн чадавхийг үнэлэхэд банк, санхүүгийн байгууллагаас тендерт оролцогчид зээл олгосон буюу зээлжих эрхтэй тухай албан ёсны мэдэгдэл, баримт бичгээс бусад аливаа тодорхойлолт, зээл судлан үзэх боломжтой зэрэг банкинд бодитой санхүүгийн үүрэг хүлээлгээгүй мэдэгдлийг тендер хянан үзэх, үнэлэхэд харгалзан үзэхгүй ба ийм тодорхойлолт ирүүлэхийг захиалагч шаардахгүй.
- 19.6. Тендерт оролцогч түншлэл нь санхүүгийн чадавхийн талаар ТШЗ 19.2-т тавьсан шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд түншлэлийн гишүүн тус бүрийн үзүүлэлтийг хооронд нь нэмж тооцно. Гэхдээ түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ 19.2-т тавьсан шалгуур үзүүлэлтийн доод тал нь 25 хувийг, төлөөлөх эрх бүхий гишүүн доод тал нь 40 хувийг хангасан байх шаардлагатай бөгөөд нийлбэр нь ТШЗ 19.2-т заасан дүнгээс багагүй байна.
- 19.7. Тендерт оролцогч нь хуулийн 16 дугаар зүйлд зааснаар гэрээний үүргийн биелэлтийг хангах техникийн чадавхи болон туршлагын талаар ТӨХ-д тавигдсан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан болохыг нотлох дараах баримт бичгээс захиалагчийн аль шаардсан баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:
- 19.7.1. бараа нийлүүлэхэд шаардлагатай ТӨХ-д заасан тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл;
- 19.7.2. тендерт оролцогч өөрөө үйлдвэрлээгүй барааг нийлүүлэхээр санал болгох тохиолдолд уг барааг нийлүүлэх боломжтой болохыг нотолсон буюу нийлүүлэгч, үйлдвэрлэгчтэй байгуулсан гэрээ, тэдгээрээс энэ тухай гаргасан албан бичиг;
- 19.7.3. гэрээг хэрэгжүүлэх удирдах, хяналт тавих, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар, туршлагын талаарх ТӨХ-д шаардсан мэдээлэл;
- 19.7.4. тендерт оролцогчийн туршлагыг харуулах ТӨХ-д заасан сүүлийн 5 хүртэлх жилийн хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй гэрээний талаарх мэдээлэл болон одоо хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний талаар Бүлэг III-т заасан маягтын дагуу бэлтгэсэн мэдээлэл;
- 19.7.5. гэрээний дагуу хийгдэх засвар, үйлчилгээ, техникийн тодорхойлолтод заасан сэлбэг хэрэгслийг нийлүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт бизнесийн үйл ажиллагаа явуулдаггүй тендерт оролцогч нь Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрөө

гүйцэтгэх, эсхүл уг тендерт оролцогчийн Монгол Улсад байгуулсан, эсхүл байгуулагдах төлөөлөгч биелүүлэх тухай баримт;

- 19.7.6. Барааны техникийн тодорхойлолтод нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээ үзүүлэхийг ТӨХ-д шаардсан бол Монгол улсын гарал үүсэлтэй бус бараа нийлүүлэхээр санал болгосон тендерт оролцогч нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг хэрхэн үзүүлэх талаар мэдээлэл, баримт;
- 19.7.7. бараа нийлүүлэхэд ашиглагдах ТӨХ-д заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл болон цаг хугацаанд нь (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах санал.
- 19.8. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгчийг ТШЗ-ны 19.2, 19.7-д заасан санхүүгийн, техникийн чадавхийн болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагын түүнд холбогдох хэсгийн шаардлагыг хангаж байгааг нотлох зорилгоор зохих тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл болон бусад баримт бичгийг тендерт ирүүлнэ.
- 19.9. Тендерт оролцогч ТШЗ-ны 19.7-д заасан техникийн чадавхи болон туршлагын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд түншлэлийн гишүүн тус бүрийн үзүүлэлтийг хооронд нь нэмж тооцно.
- 19.10. Түншлэл нь ТШЗ-ны 19.1-д зааснаар захиалагчийн тогтоосон доод шалгуур үзүүлэлт, шаардлагыг түншлэлийн гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна.
- 20. Санал болгож буй бараа тендерийн баримт бичгийн шаардлагад нийцэж буйг нотлох баримт бичиг**
- 20.1. Нийлүүлэхээр санал болгож буй бараа нь ТШЗ-ны 7-д заасан гарал үүслийн шаардлагыг хангаж буй болохыг харуулахын тулд тендерт оролцогч нь барааны гарал үүслийг Бүлэг III дахь Үнийн хуваарийн холбогдох хэсэгт бөглөж ирүүлнэ.
- 20.2. Тендерт оролцогч нь санал болгож буй бараа нь Бүлэг IV-т заасан техникийн тодорхойлолтод нийцэж буйг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.
- 20.3. Нотлох баримт нь нийтлэл, зураг, өгөгдлийн хэлбэрээр байж болох ба санал болгож буй бараа нь техникийн тодорхойлолтод нийцэж буйг харуулах зорилгоор тэдгээрийн техникийн болон гүйцэтгэлийн үзүүлэлтийг техникийн тодорхойлолттой нэг бүрчлэн харьцуулсан тайлбар, хэрэв тус тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай мэдэгдэл ирүүлнэ.
- 20.4. Барааг ашиглаж эхэлснээс хойш ТӨХ-д заасан хугацааны туршид тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалт ирүүлнэ. Тус

жагсаалтад тэдгээрийг хаанаас авах боломжтойг болон одоогийн үнэ нь ямар байгаа тухай мэдээллийг дурдана.

- 20.5. Техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал болон тоног төхөөрөмжийн загвар, стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар зэрэг нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд түүгээр хязгаарлагдахгүй. Тиймээс тендерт оролцогч захиалагчийн бараа худалдан авч буй хэрэгцээг хангахуйц өөр чанар, материал болон тоног төхөөрөмжийн загвар, стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар бүхий барааг санал болгож болох ба энэ тохиолдолд орлуулах зүйл нь техникийн тодорхойлолтод заасантай дүйцэхүйц, эсхүл түүнээс илүү шаардлага хангасан байна.
- 20.6. Хуулийн 10 дугаар зүйлийн дагуу давуу эрх эдлэх бол үнийн хуваарьт үнийг нь бууруулан тооцох бараа болон хуулийн 10¹ дүгээр зүйлийн дагуу нийлүүлэхээр санал болгож буй бараа тус бүрийн гарал үүслийг ТШЗ-ны 20.1-д зааснаар Үнийн хуваарьт заавал тусгаж ирүүлэх ба бараа тус бүрийн Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт, материалыг тендерт хавсарган ирүүлнэ. Энэ баримт, материалыг ирүүлээгүй бараанд давуу эрх олгохгүй ба дотоодын үйлдвэрээс худалдан авах барааны багцад тус барааг шалгаруулахгүй.
- 20.7. Барааны чанарын баталгаат болон зүгшрүүлэх тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор уг хугацаа дуустал чанарын баталгаа ирүүлэхийг захиалагч ТӨХ-д зааж болно. Чанарын баталгааны нөхцөлийг хүлээн зөвшөөрөхгүй тухай тусгайлан заасан тендерийг шаардлага хангаагүй гэж үзэж татгалзана.
- 21. Тендерийн үнэ болон үнийн хөнгөлөлт**
- 21.1. Тендер илгээх маягт болон үнийн хуваарь дахь тендерт оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ ТШЗ 21-д заасан шаардлагад нийцсэн байна.
- 21.2. Үнийн хуваарьт бүх багц болон нэр төрлийг үнэ тус бүрээр нь тусад нь жагсааж ирүүлнэ.
- 21.3. Тендер илгээх маягтад тусгасан үнэ нь аливаа үнийн хөнгөлөлтийг тооцоогүй тухайн тендерийн нийт үнэ байна.
- 21.4. Тендерт оролцогч нь ТШЗ-ны 16-д зааснаар бөглөх Тендер илгээх маягтад аливаа үнийн хөнгөлөлт болон түүнийг хэрэглэх аргачлалыг тусгасан байна.
- 21.5. ТӨХ-д өөрөөр заагаагүй бол тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх ба ямар нэг тохируулга хийхгүй ба тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзэж татгалзана. Гэхдээ ТӨХ-д үнийн тохируулга хийхийг

зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба түүний үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

- 21.6. ТШЗ-ны 1.1-д зааснаар тендерт оролцогч нь нэг ба хэд хэдэн багцад тендер илгээх эрхтэй.
- 21.7. Захиалагч тендерт оролцогчийг тодорхой багц дахь бараанаас хамгийн багадаа хэдэн хувийг нийлүүлэхээр санал ирүүлж болох тухай ТӨХ-д зааж болно.
- 21.8. ТШЗ-ны 21.7-д зөвшөөрсний дагуу санал ирүүлж байгаагаас бусад тохиолдолд санал болгож буй үнэ нь багц тус бүрт заасан бүх барааг, түүнчлэн бараа тус бүрийн бүх тоо хэмжээтэй таарсан байна. Нэгээс дээш тооны багцад шалгарсан тохиолдолд үйлчлэх үнийн хөнгөлөлт санал болгож байгаа тендерт оролцогч нь тэдгээр багцуудад санал болгосон нийт үнийн дүнгээс, эсхүл тэдгээрийн аль нэг багцад санал болгосон үнийн дүнгээс хөнгөлөлт үзүүлэх тухай тендерт зааж болно.
- 21.9. Бараа нийлүүлэх тендерт Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэхдээ Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргасан Incoterms-ийн хамгийн сүүлийн хувилбарын Delivery Duty Paid /DDP/ (уг нөхцөлийг өөрчлөх бол ТӨХ-д захиалагч зааж өгнө) нөхцөлөөр ТӨХ-д дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.
- 21.10. Барааны үнийг Бүлэг III-т заасан үнийн хуваарь бүрээр гаргаж ирүүлнэ. Үнийн задаргаа нь зөвхөн захиалагчаас тендерийг харьцуулж үнэлэх зорилгоор ашиглагдана. Энэ нь санал болгосон нөхцөлийн тодорхой нэг нөхцөлийг сонгон гэрээ байгуулах захиалагчийн эрхийг хязгаарлахгүй.
- 21.11. Үнийн задаргаанд бараа нийлүүлэхтэй холбоотой тээвэрлэлтийн болон даатгалын зардал, татвар, хураамжийг тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд эдгээр зардлыг багтсанд тооцно.
- 21.12. Гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар хураамжийг тендер хүлээж авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнөх өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг үндэслэн тендерийн үнэд багтаасан байна.
- 21.13. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг тооцож, нэг валютад хөрвүүлсэн тендерийн үнэ байна.
- 22. Тендерийн валют**
- 22.1. Хуульд өөрөөр заагаагүй бол тендерийн үнэ нь Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2 дахь хэсэгт заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.

23. Тендер хүчинтэй байх хугацаа

- 23.1. Тендер нь ТШЗ-ны 26-д зааснаар захиалагчийн тогтоосон тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 30-аас доошгүй хоногийн хугацаанд хүчинтэй байна. Тендер хүчинтэй байх хугацааг үүнээс багаар тогтоосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзэж татгалзана.
- 23.2. Хуульд заасан үндэслэлээр тендер шалгаруулалт зохион байгуулах хугацааг эрх бүхий байгууллагаас сунгахаар шийдвэрлэсэн тохиолдолд захиалагч бүх оролцогчдод хандаж өөрсдийн тендер хүчинтэй байх хугацааг сунгах хүсэлт тавина. Энэхүү хүсэлтийн хариуг тендерт оролцогч цахим системээр дамжуулан тоон гарын үсэг ашиглан хүргүүлж болно. Хэрэв ТШЗ-ны 24-т зааснаар тендерийн баталгаа шаардсан бол тендер шалгаруулалтын оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгах хүсэлтийг зөвшөөрвөл түүний тендерийн баталгааны хүчинтэй хугацаа мөн адил сунгагдана. Хүсэлтийг зөвшөөрсөн тендерт оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаанаас өөр өөрчлөлтийг тендерт оруулахыг зөвшөөрөхгүй ба өөр өөрчлөлт оруулахыг шаардахгүй.
- 23.3. Тендерт оролцогч өөрийн тендер хүчинтэй байх хугацааг сунгахаас татгалзах эрхтэй ба ийнхүү татгалзсан үндэслэлээр түүний тендерийн баталгааг улсын орлого болгохгүй.
- 23.4. Урьдчилсан худалдан худалдан авах ажиллагаанд оролцогч нь тендерийн хүчинтэй байх хугацаа нь санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байна. Гэхдээ захиалагч бусад тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосон бөгөөд захиалагчийн шийдвэрийн талаар гомдол гаргах хугацаа дууссан бол шалгараагүй тендерт оролцогч нь өөрийн тендерийн хүчинтэй хугацааг дуусгавар болгох тухай мэдэгдлийг захиалагчид хүргүүлж болно.

24. Тендерийн баталгаа

- 24.1. ТӨХ-д шаардсан тохиолдолд тендерт оролцогч нь захиалагч барааны төсөвт өртгийн нэг (1) хувиар тооцсон буюу ТӨХ-д заасан үнийн дүнгээс багагүй төлбөрийн үүрэг хүлээх тухай тендерийн баталгааг холбогдох этгээдээр гаргуулан ирүүлнэ.
- 24.2. Тендер шалгаруулалт олон багцтай бол багц тус бүрээр тендерийн баталгаа ирүүлнэ.
- 24.3. Тендерийн баталгаа нь Монгол Улсын, эсхүл гадаадын банкны гаргасан баталгаа, Засгийн газрын бонд эсхүл Засгийн газраас хүлээн зөвшөөрсөн үнэт цаасны хэлбэрээр байж болох ба Бүлэг III дахь маягыг ТШЗ-ны 16-д зааснаар бэлтгэсэн байна.
- 24.4. ТШЗ-ны 24.5-д зааснаас бусад тохиолдолд цахим худалдан авах ажиллагаанд оролцогч нь тендерийн баталгааг холбогдох журамд зааснаар цахим системээр дамжуулан хүргүүлнэ.

- 24.5. Гадаадын хуулийн этгээд гадаадын банкны баталгаа гаргуулсан, гадаадын болон Монгол Улсын хуулийн этгээд нь гадаад улс дахь эрх бүхий этгээдээс Монгол Улсын Засгийн газрын бонд болон Монгол Улсын Засгийн газраас зөвшөөрсөн бусад үнэт цаас хэлбэрээр тендерийн баталгаа гаргуулах бол дараах шаардлагыг хангасан байна:
- 24.5.1. тендерийн баталгааны эх хувийг орчуулгын хамт холбогдох журамд зааснаар захиалагчид хүргүүлэх;
- 24.5.2. баталгааны дагуу хүргүүлэх шаардлагыг баталгаа гаргагчийн нэрийн өмнөөс хүлээн авах Монгол Улсад үүсгэн байгуулагдсан банк, санхүүгийн байгууллагыг зааж ирүүлэх.
- 24.6. Тендерт оролцогчийн ирүүлэх баталгаа нь түүний ирүүлсэн тендерийн баталгааны ТШЗ-ны 23-т заасан хугацаанаас хойш хорин найм (28) хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 24.7. ТШЗ-ны 24.1-д зааснаар тендерийн баталгаа шаардсан бол зохих шаардлага хангасан тендерийн баталгаа ирүүлээгүй тендерийг шаардлага хангаагүй гэж үзэж татгалзана.
- 24.8. Тендер шалгаруулалтад шалгараагүй тендерт оролцогчийн тендерийн баталгааны ТШЗ-ны 24.7-д заасан хугацаа дууссан, эсхүл энэ хугацаанаас өмнө захиалагч бусад этгээдтэй гэрээ байгуулсан ба гүйцэтгэлийн баталгааг хүлээн авсан тухай мэдэгдлийг захиалагчаас хүлээн авсан бол баталгаа гаргагч нь тухайн шалгараагүй тендерт оролцогчийн тендерийн баталгааг хүчингүй болгож болно.
- 24.9. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.
- 24.10. Захиалагч шалгарсан тендерт оролцогчтой ТШЗ-ны 43-т заасны дагуу гэрээнд гарын үсэг зурж, ТШЗ-ны 44-т заасны дагуу гүйцэтгэлийн баталгаа хүлээн авсны дараа бүх оролцогчийн тендерийн баталгааг хүчингүй болгохыг зөвшөөрсөн мэдэгдлийг гаргана. Захиалагч цахим системээр хүлээн авсан тендерийн баталгааг хүчингүй болгохыг зөвшөөрсөн мэдэгдлийг цахим системээр дамжуулан гаргана.
- 24.11. Баталгаа гаргагч нь шалгарсан тендерт оролцогчийн тендерийн баталгааг ТШЗ-ны 24.10-т заасан мэдэгдлийг хүчингүй болгоно.
- 24.12. Тендерийн баталгааг дараах тохиолдолд улсын орлого болгоно. Үүнд:
- 24.12.1. тендер нээсний дараа, өөрийн хүргүүлсэн тендерийн хүчинтэй байх хугацаа (ТШЗ-ны 23-т зааснаар сунгасан хугацааг оролцуулан) дуусахаас өмнө тендерт оролцогч нь тухайн тендерээс бүхэлд нь

эсхүл хэсэгчлэн татгалзсанаа бичгээр мэдэгдсэн;

24.12.2. захиалагч тендер хүчинтэй байх хугацаанд багтаж гэрээ байгуулах эрх олгосон үед тендерт оролцогч:

24.12.2.1. ТШЗ-ны 43-т заасны дагуу гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулаагүй;

24.12.2.2. ТШЗ-ны 44-т заасны дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй;

24.12.2.3. ТШЗ-ны 34-т заасны дагуу тендерийн үнэд хийсэн арифметик алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй, эсхүл зөвшөөрсөн эсэх тухай хариуг бичгээр ирүүлээгүй.

24.12.3. төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тендерт оролцогчийн гаргасан гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.

24.13. Баталгаа гаргагч нь тендерийн баталгааг улсын орлого болгосон мөнгөн хөрөнгийг Монгол Улсын Сангийн яамны холбогдох дансанд, Монгол Улсын Засгийн газрын бонд болон Монгол Улсын Засгийн газраас зөвшөөрсөн бусад үнэт цаасыг Монгол Улсын Сангийн яамны нэр дээр тус тус шилжүүлнэ.

Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

25. Тендер баталгаажуулах, илгээх

25.1. Тендер шалгаруулалтад илгээх тендерийн холбогдох маягтуудыг эрх бүхий этгээд гарын үсгээр баталгаажуулах ба итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдийн үйлдсэн баримт бичиг нь тамга тэмдгээр баталгаажих хуулийн шаардлагатай бол энэ шаардлагыг хангасан байна. Үүсгэн байгуулагдсан улсын хууль тогтоомжоор шаардаагүй бол тамга, тэмдэг дарахгүй байж болно.

25.2. Хуулийн этгээдээс итгэмжлэлээр эрх олгогдсон этгээд нь гарын үсгээр, эсхүл тоон гарын үсгээр тендерийг баталгаажуулсан нь шаардлага хангасанд тооцогдоно.

25.3. Тендерт оролцогч тендерийг холбогдох журмын дагуу цахим системээр илгээнэ.

25.4. Монгол Улсад үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд ТШЗ-ны 25.3-т зааснаар тендер илгээхдээ итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдийн тоон гарын үсгээр баталгаажуулсан бол тендерийг бүхэлдээ ТШЗ-ны 25.1-т заасан шаардлагыг хангасан гэж үзэх ба энэ тохиолдолд тендерт итгэмжлэл үйлдэж ирүүлэх болон тендерийн

маягтуудад хуулийн этгээдийн тамга, тэмдэг дарсан байх шаардлага тавихгүй.

- 25.5. Тендерт оролцогч ТШЗ-ны 25.6-д зааснаар тендерийн холбогдох хэсгийг нууцлахаас бусад тохиолдолд тендерийг бүхэлд нь бусад тендерт оролцогчдод ил болгохоор буюу нууцлахгүй ирүүлнэ. Ингэхдээ дараах баримт бичгийг заавал ил болгохоор ирүүлнэ:
- 25.5.1. Ерөнхий нөхцөлийг магадлахтай холбоотойгоор ТШЗ-ны 18-ын дагуу ирүүлсэн бүх баримт бичиг;
- 25.5.2. Бүлэг III-т заасан маягтын дагуу бэлтгэж ирүүлсэн бүх баримт бичиг;
- 25.5.3. Ил болгож ирүүлэхээр ТӨХ-д заасан бусад баримт бичиг.
- 25.6. Тендерт оролцогч тендерээс Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуульд заасан үндэслэлээр нууцалж ирүүлж болох боловч ийнхүү нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарласан тайлбарыг нууцаар илгээх баримт бичгийн эхэнд тайлбарласан байна.
- 26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**
- 26.1. Тендерийг ТӨХ-д заасан огноо, цагаас өмнө, цахим худалдан авах ажиллагааны хувьд цахим системийн цагийг баримтлан цахим системээр дамжуулан холбогдох журмыг баримтлан хүргүүлнэ.
- 26.2. Захиалагч ТШЗ-ны 12-т зааснаар тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгасан бол тендер хүлээн авах эцсийн хугацаатай холбоотойгоор тодорхойлогдох захиалагч болон тендерт оролцогчийн эрх, үүрэг нь сунгагдсан хугацаагаар тодорхойлогдоно.
- 27. Тендерт нэмэлт өөрчлөлт хийх, тендерийг буцааж авах**
- 27.1. Тендерт оролцохыг сонирхогч этгээд, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө өөрийн тендерт нэмэлт өөрчлөлт оруулах, солих, эсхүл түүнийг буцааж авч болно.
- 27.2. Тендер хүлээн авах эцсийн хугацаа өнгөрснөөс хойш аливаа тендерийн хүчинтэй байх хугацаа дуусах хүртэл тухайн тендерт ямар нэг нэмэлт, өөрчлөлт оруулах, түүнийг солих, эсхүл буцааж авахыг зөвшөөрөхгүй.
- 27.3. Тендерт оролцогч илгээсэн тендерээсээ тендерийн нээлтээс хойш татгалзах хүсэлтэй бол энэ тухай захиалагчид албан бичгээр мэдэгдэнэ.
- 28. Тендерийг нээх**
- 28.1. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр дамжуулан ТӨХ-д заасан огноо, цагт, заасан газарт зохион байгуулна.
- 28.2. ТШЗ-ны 28.1-д заасан газар зохион байгуулж буй тендерийн нээлтэд тендерт оролцогч, эсхүл түүний төлөөлөгч болон сонирхсон бусад этгээд байлцах

эрхтэй ба нээлтэд биечлэн оролцсон бол тендерийн нээлтийн тэмдэглэлд гарын үсгээ зурна.

28.3. Тендерийг нээх үед дараах мэдээлэл бүхий тендерийн нээлтийн тэмдэглэлийг цахим системд байршуулна. Үүнд:

28.3.1. тендерт оролцогчийн нэр;

28.3.2. тендерийн үнэ, цахим худалдан авах ажиллагааны хувьд цахим системийн холбогдох талбарт бичсэн тендерийн үнэ;

28.3.3. санал болгосон бол үнийн хөнгөлөлт;

28.3.4. хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд саналын хувилбарын үнэ;

28.3.5. тендерийн баталгаа ирүүлсэн эсэх;

28.3.6. захиалагч шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.

28.4. Нэгээс дээш багцтай тендер шалгаруулалтын үед дээрх мэдээллийг багц тус бүрээр мэдээлнэ.

28.5. Тендер нээлтэд зарлагдаагүй буюу тэмдэглэлд заагаагүй үнэ, үнийн хөнгөлөлтийг үнэлгээнд харгалзахгүй. Гэхдээ энэ нь холбогдох журмын дагуу тендерийн үнийн арифметик алдааг залруулсан болон ТШЗ-ны 33-т зааснаар нэг валютад хөрвүүлсэн тохиолдолд хамаарахгүй.

Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ

29. Нууцлах

29.1. Тендерийг хянан үзэх, тодруулах, үнэлэх, харьцуулах болон гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжтэй холбогдсон мэдээллийг гэрээ байгуулах эрх олгох хүртэлх хугацаанд тендерт оролцогчид болон тухайн тендер шалгаруулалтын үйл ажиллагаатай албан ёсоор холбогдолгүй аливаа этгээдэд задруулахгүй.

29.2. Захиалагч тендерт оролцогчоос ТШЗ-ны 25.5-д заасны дагуу ил болгохоор ирүүлсэн баримт бичгийг холбогдох журамд заасны дагуу ил болгох бөгөөд ийнхүү ил болгоход татгалзах зүйлгүй тухай мэдэгдлийг тендерт оролцогч тендер илгээх маягтын дагуу гаргана.

29.3. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойшхи тендер шалгаруулалттай холбоотой аливаа асуудлаар тендерт оролцогч болон захиалагч зөвхөн албан бичгээр, хэрэв цахим системээр харилцсан харилцааг хууль ёсны гэж үзэх шаардлагыг хангасан бол цахим системээр тус тус харилцана.

30. Тендерийн талаар тайлбар, тодруулга авах

30.1. Захиалагч нь тендерийг хянан үзэх, үнэлэх, харьцуулах, магадлах шатанд тендерт оролцогчийн ирүүлсэн тендер дэх баримт бичиг болон цахим системтэй холбогдсон мэдээллийн баазаас дамжуулсан мэдээлэл нь ойлгомжгүй, тодорхойгүй,

- зөрчилдөөнтэй байгаа тохиолдолд зөвхөн уг асуудлыг тодруулах, тайлбар авах зорилгоор тендерт оролцогчийг энэ зүйлд заасан шаардлагыг хангасан тодруулга ирүүлэхийг шаардах, эсхүл холбогдох бусад этгээдээс энэ тухай лавлагаа тодорхойлолт авах хүсэлт гаргах арга хэмжээ авч болно.
- 30.2. ТШЗ-ны 30.1-д зааснаар тайлбар, тодруулга авах ажиллагааг бичгээр явуулна.
- 30.3. ТШЗ-ны 34-т зааснаар хийсэн арифметик залруулгыг хүлээн зөвшөөрөхөөс бусад тохиолдолд тендерийн үнэ болон тендерийн агуулгад ямар нэг өөрчлөлт хийхийг хүсэх, санал болгох, эсхүл энэ тухай зөвшөөрөл олгохгүй.
- 30.4. Захиалагч нь энэ зүйлд заасан асуудлыг тодруулахдаа холбогдох төрийн эрх бүхий байгууллагаас олон нийтэд нээлттэй байршуулсан мэдээллийг үндэслэх бол энэ тухай тэмдэглэлд тусгаж баталгаажуулсан байна.
- 30.5. Хэрэв тендерт оролцогч болон холбогдох бусад этгээд нь захиалагчийн хүсэлтэд дурдаагүй асуудлаар тайлбар тодруулга ирүүлсэн, эсхүл энэ зүйлд заасан шаардлагыг хангаагүй хариу ирүүлсэн бол тухайн тайлбар тодруулгыг тендер хянан үзэх, үнэлэх, магадлахад харгалзан үзэхгүй.
- 31. Тендерийг хянан үзэх, шаардлагад нийцсэн эсэхийг тогтоох**
- 31.1. Захиалагч тендерийг шаардлага хангаж байгаа эсэхийг хянан үзэхдээ ТШЗ-ны 15-д заасан иж бүрдэлд үндэслэн дараах шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянан үзнэ.
- 31.1.1. Тендерт оролцогч нь ТШЗ-ны 4-т заасан эрх бүхий этгээд байх;
- 31.1.2. Түншлэл нь ТШЗ-ны 5-д заасан шаардлагыг хангасан байх;
- 31.1.3. ТШЗ-ны 6-д зааснаар зөвхөн нэг тендер ирүүлсэн байх;
- 31.1.4. Нийлүүлэх барааны гарал үүсэл нь ТШЗ-ны 7-д заасан шаардлагыг хангасан байх;
- 31.1.5. Бүлэг III дахь маягтын дагуу ирүүлсэн баримт бичиг нь холбогдох шаардлага хангасан байх;
- 31.1.6. ТШЗ-ны 18-д заасны дагуу ирүүлсэн баримт бичиг болон холбогдох мэдээллийн баазаас дамжуулсан мэдээллийн дагуу хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасан нөхцөл тогтоогдоогүй байх;
- 31.1.7. ТШЗ-ны 19-т заасны дагуу ирүүлсэн баримт бичгээр тендерт оролцогч санхүүгийн, техникийн чадавхийн болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан байх;
- 31.1.8. ТШЗ-ны 20-д заасны дагуу ирүүлсэн баримт бичгээр санал болгож буй бараа нь тендерийн баримт бичгийн шаардлагад нийцэж байх;
- 31.1.9. тендерийг баталгаажуулах, илгээхдээ ТШЗ-ны 25-д заасан шаардлагыг хангасан байх;
- 31.1.10. тендерийн баримт бичигт тавигдсан бусад шаардлагад нийцсэн байх.

- 31.2. ТШЗ-ны 31.1.7, 31.1.8-д заасан шаардлага хангасан эсэхийг хянан үзэх, магадлахдаа дараах томоохон зөрүүгүй бол шаардлага хангасан гэж үзнэ:
 31.2.1. тендерт санал болгож буй барааны тодорхойлолт болон гэрээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхээр бол;
 31.2.2. гэрээнд заасан захиалагчийн эрх, тендерт оролцогчийн үүрэгт тендерийн баримт бичигтэй үл нийцэх зарчмын хязгаарлалт оруулсан бол.
- 31.3. ТШЗ-ны 31.2-т заасан томоохон зөрүү гэж тооцоогүй бага хэмжээний орхигдуулсан зүйл буюу тоо хэмжээний зөрүүг тооцон мөнгөөр илэрхийлж, тендерийн үнэд залруулга хийнэ.
- 31.4. Шаардлагад нийцсэн тендер гэж ТШЗ-ны 31-ийн дагуу хянан үзэхэд тендерийн баримт бичгийн бүх нөхцөл, шаардлагыг буюу ТШЗ-ны 3-7 дугаар зүйл, В, Г дэд бүлгүүдэд заасан шаардлагыг нэгэн зэрэг хангаж байгаа байгаа, түүнд заасан баримт бичиг, тендер илгээх маягт болон бусад маягтуудыг зохих ёсоор ирүүлсэн, маягтуудын агуулгын өөрчлөлт оруулаагүй тендерийг хэлнэ.
- 31.5. ТШЗ-ны 31.4-т зааснаас бусад тендерийг шаардлагыг нийцээгүй гэж үзэж, уг тендерээс татгалзана.
- 31.6. ТШЗ-ны 31.5-д зааснаар тендерээс татгалзахдаа захиалагч тендерт оролцогчоос шаардахгүй тухай тендерийн баримт бичигт тусгайлан заасан баримт бичгийг ирүүлээгүй, эсхүл ирүүлсэн баримт бичиг нь шаардлага хангаагүй гэсэн үндэслэлээр татгалзахгүй.
- 32. Тендерийг үнэлэх**
- 32.1. Захиалагч зөвхөн ТШЗ-ны 31.4-т заасан шаардлагад нийцсэн гэж тогтоогдсон тендерийг энэ тендерийн баримт бичиг, ТӨХ-д заасан үнэлгээнд харгалзах бусад шалгуур үзүүлэлт болон холбогдох бусад хууль тогтоомжид зааснаар үнэлж, харьцуулна.
- 32.2. Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах тендер шалгаруулалтын үнэлгээг энэхүү баримт бичигт заасан үнэлгээний аргачлал, зааврын дагуу үнэлж харьцуулна.
- 33. Нэг валютад хөрвүүлэх**
- 33.1. Тендерийн үнэ болон түүний бүрдлийг ТШЗ-ны 22-д зааснаас өөр валютаар тендерийн үнийг илэрхийлсэн тохиолдолд тендерийг үнэлэх, харьцуулахдаа тендер шалгаруулалт зарласан өдрийн Монгол банкны албан ханшийг үндэслэн тендерийн үнийг нэг валютад хөрвүүлнэ.
- 34. Арифметик алдааг залруулах**
- 34.1. Захиалагч шаардлагад нийцсэн гэж үнэлсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна. Үүнд:
 34.1.1. нэр төрлийн мөр дэх нийт үнэ нь түүний нэгж үнийг тоо ширхгээр үржүүлэхэд гарсан үнээс зөрвөл нэгж үнийг үндэслэн түүний мөр дэх нийт үнийг залруулна. Гэхдээ нэгж үнийн аравтын орны таслалыг илэрхий алдсан байна гэж захиалагч үзвэл тухайн мөр дэх

- нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна;
- 34.1.2. мөр дэх үнийн нийлбэр эсхүл ялгаварт алдаа байвал мөр дэх үнийг үндэслэн нийт үнийг залруулах;
- 34.1.3. тоо болон үгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзэж тоон дүнг залруулна. Гэхдээ үгээр илэрхийлсэн дүн нь арифметик алдаанаас шалтгаалсан бол ТШЗ-ны 34.1.1, 34.1.2-т нийцүүлэн тоогоор илэрхийлсэн дүнг баримтална.
- 34.2. ТШЗ-ны 34.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг тендерт оролцогчид хүргүүлнэ.
- 35. Давуу эрх олгох**
- 35.1. Захиалагч нь хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.3, 10.1.6 дахь заалтад заасан этгээдээс ТШЗ-ны 20.6-д зааснаар давуу эрх эдлэх барааны Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотолж ирүүлсэн барааны хэсгийн үнийг Хууль болон холбогдох аргачлалд зааснаар хийсвэрээр бууруулж тооцно.
- 35.2. ТШЗ-ны 1.2-т зааснаар дотоодын үйлдвэрээс худалдан авах багцад ирүүлсэн тендерт давуу эрх олгохгүй.
- 36. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох**
- 36.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлохдоо дараах зүйлийг харгалзана:
- 36.1.1. ТШЗ-ны 21-д зааснаар санал болгосон тендерийн үнэ;
- 36.1.2. ТШЗ-ны 34.1-д заасны дагуу тендерийн үнэд хийсэн арифметик залруулга;
- 36.1.3. ТШЗ-ны 21.4-д заасны дагуу санал болгосон үнийн хөнгөлөлт тооцсон үнэ
- 36.1.4. ТШЗ-ны 36.1.1-36.6.3-т заасан үнийг шаардлагатай бол ТШЗ-ны 33-т зааснаар нэг валютад хөрвүүлэх;
- 36.1.5. ТШЗ-ны 31.3-т зааснаар бага хэмжээний орхигдуулсан зүйл буюу тоо хэмжээний зөрүүг мөнгөөр тооцож залруулсан үнэ;
- 36.1.6. ТШЗ-ны 32.1-т заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж тооцсон үнэ.
- 36.2. ТШЗ-ны 1.2-т заасны дагуу хоёр ба түүнээс дээш багцтай тендер шалгаруулалтад хэд хэдэн багцад хамтад нь хамгийн бага харьцуулах үнэ санал болгосон тендерийг тодорхойлох, түүнд санал болгосон үнийн хөнгөлөлтийг тооцохдоо дараах аргачлалыг баримтална. Үүнд:
- 36.2.1. ТШЗ-ны 21.7-д заасан хувь хэмжээг хангасан барааг санал болгосон багцийг үнэлгээнд тооцох;

- 36.2.2. багц тус бүрийн хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг ТШЗ-ны 36.1-д заасны дагуу сонгох;
- 36.2.3. хоёр ба түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлэхээр санал болгосон тендерийн үнээс уг үнийн хөнгөлөлтийг тендер илгээх маягтад тодорхойлсон аргачлалын дагуу тооцсоны дараагаар шаардлагатай бол түүний харьцуулах үнийг дахин тодорхойлно. Ийнхүү тодорхойлохдоо хоёр ба түүнээс дээш багцад хамгийн бага харьцуулах үнэтэй тендер ирүүлсэн этгээд нь ТШЗ-ны 38.3-т зааснаар дахин магадлахад шаардлага хангаж байхыг шаардана;
- 36.2.4. дээрх үнэлгээг хийсний дараа тендерийн харьцуулах үнэд үндэслэн захиалагч гэрээ байгуулах эрхийг нэг багцад, хэд хэдэн багцад, эсхүл бүх багцад олгох хувилбаруудыг тооцож, тэдгээрээс хамгийн үр ашигтай хувилбарыг сонгох.
- 36.3. ТШЗ-ны 17.1-д заасны дагуу хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд “хамгийн сайн” үнэлэгдсэн үндсэн тендерээр ирүүлсэн саналын хувилбарыг хянан үзэж, үнэлнэ.
- 36.4. ТШЗ-ны 36.3-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхдээ үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
- 37. Тендерийг харьцуулах**
- 37.1. Захиалагч “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийг сонгохдоо хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.3 дахь хэсэгт заасны дагуу тендерүүдийг бага харьцуулах үнэтэйгээс их харьцуулах үнэтэй рүү нь эрэмбэлж, хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг сонгоно.
- 38. Тендерт оролцогчийн чадварыг дахин магадлах**
- 38.1. Захиалагч нэг ба хэд хэдэн багцад “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхитай эсэхийг дахин магадлаж болно.
- 38.2. ТШЗ-ны 38.1-т зааснаар дахин магадлахдаа зөвхөн ТШЗ-ны 19.2-т заасан санхүүгийн болон ТШЗ-ны 19.7-д заасан техникийн чадавхийн талаар шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангах эсэхийг тус зүйлүүдийн дагуу ирүүлсэн баримт бичиг болон ТШЗ-ны 30-ын дагуу авсан тодруулгад үндэслэн тогтооно.
- 38.3. Нэг тендерт оролцогч хоёр ба түүнээс дээш багцад “хамгийн сайн” үнэлэгдсэн тохиолдолд тухайн этгээдийн гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхийг ТШЗ-ны 38.2-т зааснаар дахин магадлана. Хэрэв хоёр ба түүнээс дээш багцад гэрээ байгуулахад тендерт оролцогч гэрээний үүрэг чадавхийн шаардлага хангахгүй бол тухайн этгээдийн гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхид нь тохирох нэг ба хэд хэдэн багцад гэрээ байгуулах эрх олгоно.
- 38.4. “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг дахин

магадлаад шаардлага хангасан гэж үзэх нь гэрээ байгуулах эрх олгох үндэслэл болно. Хэрэв шаардлага хангахгүй гэж магадлавал уг тендерээс татгалзан удаах “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийн чадавхийг мөн адил зарчмаар магадлана.

- 39. Захиалагч тендерээс татгалзах**
- 39.1. ТШЗ-ны 31.5-д зааснаар шаардлага хангаагүй гэж үзсэн болон шаардлага хангасан боловч “хамгийн сайн” үнэлэгдээгүй тендерт оролцогчийн тендерээс татгалзах шийдвэрийг гаргасан бол захиалагч шалгараагүй үндэслэлийг тодорхой дурдсан мэдэгдлийг тендерт оролцогчид нэгэн зэрэг бичгээр хүргүүлнэ.
- 39.2. Захиалагч бүх тендерээс татгалзсан бол ТШЗ-ны 39.1-д заасан мэдэгдэлд хуулийн 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсэгт заасан аль шийдвэрийг гаргах тухайгаа заана.

Е. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

- 40. Гэрээ байгуулах эрх олгох шалгуур**
- 40.1. Захиалагч ТШЗ-ны 38-д заасны дагуу “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно.
- 40.2. “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч ТШЗ-ны 34-т заасны дагуу тендерийн үнэд хийсэн арифметик алдааг хүлээн зөвшөөрөөгүй, эсхүл зөвшөөрсөн эсэх тухай хариуг бичгээр ирүүлээгүй бол захиалагч түүний тендерээс татгалзах бөгөөд ТШЗ-ны 24.12-т заасны дагуу түүний тендерийн баталгааг улсын орлого болгоно.
- 41. Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл**
- 41.1. Захиалагч “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө, захиалагчийн шийдвэртэй холбоотой гомдлыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргах боломжтой хугацаа дууссаны дараа гэрээ байгуулах боломжтой байхуйц хугацааны өмнө гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг холбогдох маягтын дагуу гаргаж, шалгарсан тендерт оролцогчид бичгээр хүргүүлнэ.
- 41.2. Захиалагч гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг хүргүүлэхдээ нэгэн зэрэг дараах арга хэмжээ авна:
- 41.2.1. Шалгарсан тендерт оролцогч, түүний ирүүлсэн тендерийн холбогдох хэсгийг ил болгох тухай мэдээллийг ТШЗ-ны 39-д заасан мэдэгдэлд тусгаж бусад тендерт оролцогчдод хүргүүлэх;
- 41.2.2. Тендер шалгаруулалтын үр дүнг цахим системд нийтлэх.
- 41.3. Хэрэв холбогдох журмын дагуу мэдэгдлийг цахим системд байршуулснаар мэдэгдсэнд тооцох боломжтой бол ийнхүү цахим системээр нэгэн зэрэг мэдэгдсэн нь ТШЗ-ны 41.1-т зааснаар мэдэгдэл хүргүүлсэнд тооцогдоно.
- 41.4. Захиалагч уг тендер шалгаруулалтад ашиглах гэрээний загварыг ТӨХ-д заах ба энэ тендерийн

баримт бичиг батлагдах өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй тус гэрээний загвар нь энэхүү тендерийн баримт бичгийн салшгүй нэг хэсэг болно.

- 41.5. ТШЗ-ны 43.3.1, 43.3.2-т заасан тохиолдолд захиалагч гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг хүчингүй болгож, ТШЗ-ны 24.12-т зааснаар тендерийн баталгааг улсын орлого болгоно. Энэ тохиолдолд удаахь “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийг ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг хүргүүлж, ТШЗ-ны 41.2-т заасан арга хэмжээг авна.
- 42. Тендер шалгаруулалттай холбоотой гомдол**
- 42.1. Тендерт оролцогч болон тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээд тендер шалгаруулалттай холбоотой гомдлоо Хууль болон төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан холбогдох журмын дагуу гаргана.
- 43. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах**
- 43.1. Захиалагч ТШЗ-ны 41.4-т заасан гэрээний маягтад гэрээ байгуулах эрх авсан тендерт оролцогчийн ирүүлсэн тендерийн нөхцөлийг тусгасан гэрээний төслийг шалгарсан тендерт оролцогчид хүргүүлнэ.
- 43.2. Шалгарсан тендерт оролцогч 43.1-д заасан гэрээний төсөлд гарын үсэг зурж, баталгаажуулан, гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 6 хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.
- 43.3. Захиалагч дараахаас бусад тохиолдолд шалгарсан тендерт оролцогчийн баталгаажуулж ирүүлсэн, шаардлага хангасан гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулна:
- 43.3.1. Шалгарсан тендерт оролцогч баталгаажуулсан гэрээг ирүүлээгүй;
- 43.3.2. ТШЗ-ны 44-т заасан гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй;
- 43.3.3. Шүүх, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад эрх бүхий этгээдээс гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрийг хүчингүй болгосон, түдгэлзүүлсэн.
- 43.4. Тендерт шалгарсан этгээд техникийн тодорхойлолтод нийцсэн барааг ТӨХ-д заасан хугацаанд, заасан газарт хүргэнэ.
- 44. Гүйцэтгэлийн баталгаа**
- 44.1. ТӨХ-д заасан бол шалгарсан тендерт оролцогч нь гэрээний үнийн 5 хувиас багагүй төлбөрийн үүрэг хүлээх тухай гүйцэтгэлийн баталгааг ТШЗ-ны 43.2-т заасан хугацаанд багтаан захиалагчид хүргүүлнэ.
- 44.2. Гүйцэтгэлийн баталгаа нь Монгол Улсын, эсхүл гадаадын банкны гаргасан баталгаа, Засгийн газрын бонд эсхүл Засгийн газраас хүлээн зөвшөөрсөн үнэт цаасны хэлбэрээр байж болох ба ТШЗ-ны 41.4-т

- заасан гэрээний маягт дахь гүйцэтгэлийн баталгааны загварын дагуу холбогдох этгээдээр гаргуулсан байна.
- 44.3. Гадаадын хуулийн этгээд гадаадын банкны баталгаа гаргуулсан, эсхүл аливаа тендерт оролцогч нь гадаад улс дахь эрх бүхий этгээдээс Монгол Улсын Засгийн газрын бонд болон Монгол Улсын Засгийн газраас зөвшөөрсөн бусад үнэт цаас хэлбэрээр гүйцэтгэлийн баталгаа гаргуулах бол ТШЗ-ны 24.5-д заасан шаардлагыг хангасан байна.
- 44.4. Захиалагчийн хүлээн авч, шаардлага хангасан гүйцэтгэлийн баталгаа нь гэрээний салшгүй нэг хэсэг байна.
- 44.5. ТШЗ-ны 20.7-д чанарын баталгаа шаардсан бол чанарын баталгаа хүлээн авсныг үндэслэн гүйцэтгэлийн баталгааг чөлөөлнө.
- 45. Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдаж буй тендер шалгаруулалт**
- 45.1. ТШЗ-ны 1.1-д заасан тендер шалгаруулалтыг урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулж байгаа үед энэ тухай ТӨХ-д болон тендерийн урилгад заасан байна.
- 45.2. Захиалагч ТШЗ-ны 45.1-д заасны дагуу урьдчилсан худалдан авах ажиллагааг зохион байгуулж байгаа бол тендер шалгаруулалтад энэ тендерийн баримт бичгээс гадна “Урьдчилсан худалдан авах ажиллагааны журам”-д заасан нөхцөлийг мөрдлөг болно.
- 45.3. Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдсан худалдан авах ажиллагааны үед тухайн төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр бүрэн батлагдах хүртэл гэрээ байгуулахыг хориглоно.
- 45.4. Санхүүжилтийн эх үүсвэр батлагдаагүй, мөн төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг өөрчилж баталсан нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар худалдан авах боломжгүй болсон, эсхүл цар хүрээ, хүчин чадлыг өөрчилсөн, бууруулсан тохиолдолд захиалагч тендерт оролцогчдод мэдэгдэж, гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгоно.
- 45.5. ТШЗ-ны 45.4-т зааснаар гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгосонтой холбоотой аливаа эрсдэлийг тендерт оролцогч хариуцах ба энэ тухай мэдэгдлийг тендер илгээх маягтад тусгасан.
- 45.6. Тендерийн хүчинтэй байх хугацаа дууссанаас хойш урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдсан тендер шалгаруулалтын санхүүжилт батлагдсан тохиолдолд тухайн тендер шалгаруулалтыг хүчинтэйд тооцно.
- 46. Мэдээллийн ил тод байдал**
- 46.1. Шалгарсан тендерт оролцогчийн ТШЗ-ны 24.3-т заасан материалыг гэрээ байгуулах эрх олгосон өдрөөс эхлэн тухайн тендер шалгаруулалтад оролцсон бусад тендерт оролцогч танилцах

боломжтой байхаар цахим системд ажлын 5 өдөр байршуулна.

- 46.2. Захиалагч нь хуулийн 49.4, 46.1.6-д заасан баримт бичгийг холбогдох журмын дагуу тухай бүр цахим системд байршуулж, тендерт оролцогчдыг танилцах боломж олгоно.
- 46.3. Захиалагч цахим системд дараах мэдээллийг олон нийтэд ил тод нийтэлнэ. Үүнд:
 - 46.3.1. тендер ирүүлсэн оролцогч бүрийн нэр;
 - 46.3.2. тендерийн нээлтийн үед зарлагдсан үнийн санал;
 - 46.3.3. шалгараагүй тендерт оролцогчийн нэр, тендерээс татгалзсан шалтгаан;
 - 46.3.4. шалгарсан оролцогчийн нэр, гэрээний үнийн дүн.
- 46.4. ТШЗ-ны 46.1, 46.3-т заасан мэдээллийг гэрээ байгуулах эрх олгосон өдөрт багтааж багц тус бүрээр цахим системд нийтэлнэ.

**Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж
худалдан авах чанар ба үнэлгээний арга¹**

- 1.1. Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендер шалгаруулалтын үед хамгийн бага харьцуулах үнэ (P_{min})-тэй тендерт 50 оноо (S_{max}) өгч, бусад тендерт оролцогчийн харьцуулах үнэ (P_x)-д харгалзах оноог дараах томъёогоор бодно.

$$S_x = \frac{P_{min}}{P_x} \cdot S_{max}$$

P_{min} —Хамгийн бага харьцуулах үнэтэй тендерт оролцогчийн үнэ

P_x – Тухайн тендерт оролцогчийн үнэ

S_x – Тухайн тендерт оролцогчийн оноо

S_{max} –Хамгийн бага харьцуулах үнэтэй тендерт оролцогчийн оноо

- 1.2. Чанарын үнэлгээг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ.

- 1.2.1. Эм, эмнэлгийн хэрэгсэл нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын урьдчилан баталгаажуулалтад орсон бол:

Тухайн багцын:

$0 \leq 50\%$ - 0 оноо;

$50 \leq 60\%$ - 1 оноо;

$60 \leq 70\%$ - 2 оноо;

$70 \leq 80\%$ - 3 оноо;

$80 \leq 90\%$ - 4 оноо;

$90 \leq 100\%$ - 5 оноо;

- 1.2.2. Эм, эмнэлгийн хэрэгсэл нь хатуу зохицуулалттай орны эрх бүхий байгууллагын гэрчилгээтэй бол (SRA):

Тухайн багцын:

$0 \leq 50\%$ - 0 оноо;

$50 \leq 60\%$ - 1 оноо;

$60 \leq 70\%$ - 2 оноо;

$70 \leq 80\%$ - 3 оноо;

$80 \leq 90\%$ - 4 оноо;

$90 \leq 100\%$ - 5 оноо;

- 1.2.3. Эм, эмнэлгийн хэрэгсэл нь чөлөөт худалдааны гэрчилгээтэй бол:

Тухайн багцын:

$0 \leq 50\%$ - 0 оноо;

$50 \leq 60\%$ - 1 оноо;

$60 \leq 70\%$ - 2 оноо;

$70 \leq 80\%$ - 3 оноо;

$80 \leq 90\%$ - 4 оноо;

$90 \leq 100\%$ - 5 оноо;

- 1.2.4. Эм, эмнэлгийн хэрэгсэл нь Англи, Америк, Европын фармакопейн шаардлага хангасан нотлох баримт ирүүлсэн бол:

Тухайн багцын:

$0 \leq 50\%$ - 0 оноо;

$50 \leq 60\%$ - 1 оноо;

$60 \leq 70\%$ - 2 оноо;

$70 \leq 80\%$ - 3 оноо;

$80 \leq 90\%$ - 4 оноо;

$90 \leq 100\%$ - 5 оноо;

- 1.2.5. Эм, эмнэлгийн хэрэгслийг тендерт оролцогч үйлдвэрлэдэг бол:

Тухайн багцын:

$0 \leq 50\%$ - 0 оноо;

¹ Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах тендер шалгаруулалтаас бусад тендер шалгаруулалтад энэхүү үнэлгээний зааврыг тендерийн баримт бичгээс хасна уу.

- 50 ≤ 60% - 1 оноо;
- 60 ≤ 70% - 2 оноо;
- 70 ≤ 80 % - 3 оноо;
- 80 ≤ 90 % - 4 оноо;
- 90 ≤ 100% - 5 оноо;

1.2.6. Эм, эмнэлгийн хэрэгслийн хувьд тендерт оролцогч импортолдог бол:

Тухайн багцын:

- 0 ≤ 50% - 0 оноо;
- 50 ≤ 60% - 1 оноо;
- 60 ≤ 70% - 2 оноо;
- 70 ≤ 80 % - 3 оноо;
- 80 ≤ 90 % - 4 оноо;
- 90 100% - 5 оноо;

1.3. Дотоодын үйлдвэрлэгч ТШЗ-ны 29.9.2, 29.9.3-т заасан гэрчилгээтэй гэж үзэн харгалзах оноог өгнө.

1.4. Чанар ба үнэлгээний харьцуулалтын нийт оноог ТШЗ-ны 29.8, 29.9-д заасны дагуу тооцох ба харьцуулах үнэ болон чанарын үнэлгээнд харгалзах онооны нийлбэрээр хамгийн өндөр оноо бүхий тендерийг “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж үзнэ.

$$V_x = Q_x + S_x$$

V_x – Тухайн тендерт оролцогчийн чанар ба үнэлгээний харьцуулалтын нийт оноо

Q_x – Тухайн тендерт оролцогчийн чанарын үнэлгээний оноо

БҮЛЭГ II. ТЕНДЕРИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТШЗ-ны холбогдох заалт	А. Ерөнхий зүйл
ТШЗ 1.1	Захиалагч: [захиалагчийн нэрийг бүрэн бич]
ТШЗ 1.1	Тендерийн урилгын дугаар: [тендер шалгаруулалтын урилгын дугаарыг бич]
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр болон дугаар: [тендер шалгаруулалтын нэр, дугаарыг бич]
ТШЗ 1.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: ² [Дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа:] Багц 1: багцад хамаарах бараа Багц 2: багцад хамаарах бараа [Бусад:] Багц 1: багцад хамаарах бараа Багц 2: багцад хамаарах бараа
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: [эрх бүхий этгээдээс баталсан санхүүжилтийн эх үүсвэрийг бич³]
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: [мөнгөн дүн бич] [Хэрэв багцад хуваагдсан бол багц тус бүрийн төсөвт өртгийг доорх байдлаар бич: Багц 1: _____ Багц 2: _____]
	Б. Тендерийн баримт бичгийн агуулга
ТШЗ 9.3	Тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг: Хүлээн авагчийн нэр: [хариуцсан албан тушаалтны овог, нэрийг бич] Хаяг: [хүсэлт хүлээн авах хаягийг бич]

² Засгийн газраас баталсан дотоодын үйлдвэрээс авах барааг импортын бараанаас тусад нь багцлах. Багцыг хувааж дэд багц болгон тендер шалгаруулалт зохион байгуулахгүй.

³ Жишээ нь: Улсын төсвийн хөрөнгө, орон нутгийн төсвийн хөрөнгө, тухайн байгууллагын өөрийн хөрөнгө, эсхүл зээлийн хөрөнгийн эх үүсвэр г.м –ийг тодорхой бичнэ.

	Утасны дугаар: [албан байгууллагын утасны дугаарыг бич] Цахим шуудангийн хаяг: [албан байгууллагын цахим шуудангийн хаягийг бич]
ТШЗ 10.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: [“тийм” эсхүл “үгүй” гэдгээс аль нэгийг сонгож бич] [Хэрэв “Тийм” бол уулзалт болох газар, хугацааг бич]
	В. Тендер бэлтгэх, илгээх
ТШЗ 14.2	Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр худалдан авах барааны тендерийн хэл нь [“Монгол хэл” эсхүл тендерийг гадаад хэл дээр ирүүлэх шаардлагатай гэж үзсэн бол тендерийн баримт бичгийг бэлтгэсэн гадаад хэлийг сонгож бич] байна.
ТШЗ 17.1	Тендерийг хувилбарт саналтайгаар ирүүлэхийг [“зөвшөөрнө” эсхүл “зөвшөөрөхгүй” гэдгээс аль нэгийг сонгож бич] . [Хэрэв зөвшөөрсөн бол саналын хувилбарыг үнэлэх аргачлалыг бич]
ТШЗ 19.2	Санхүүгийн тайланг цахим системээр татаж авч үнэлгээнд харгалзан үзэх хугацаа: [Захиалагч үнэлгээнд харгалзах санхүүгийн тайлангийн хугацааг тодорхой заах ба шаардлагагүй бол хэт урт хугацаа заахаас татгалзах ба тендер хүлээн авах эцсийн хугацааны байдлаар тендерт оролцогч тайлагнасан байх хуулийн шаардлага бүхий санхүүгийн жил эсхүл улирлыг зааж болно.]
ТШЗ 19.3	Тендерт оролцогчид тавигдах санхүүгийн чадавхийн шалгуур үзүүлэлт, шаардлага: [Санхүүгийн чадавхийн шалгуур үзүүлэлт, шаардлагыг тогтоохдоо бараа нийлүүлэхэд зайлшгүй шаардлагатай шалгуур үзүүлэлтийг тусгах ба хувь хэмжээг үндэслэлгүй хэт өндөр тогтоохгүй байх. Тавигдах шаардлагын жишээ нь дараахь байж болох боловч үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд: <ul style="list-style-type: none">- Бусад гэрээт ажилд ашиглагдах буюу ашиглаж буй хөрөнгө болон энэ гэрээний дагуу хийгдэж болох урьдчилгаа төлбөрийн баталгааны үнийн дүнг оролцуулахгүйгээр гэрээний үүргийн [•]-д заасан хувь хэмжээг гүйцэтгэхэд зарцуулах мөнгөн хөрөнгийн боломжтой байх;- Борлуулалтын орлогын хэмжээ [мөнгөн дүнгээр зааж өгөх/батлагдсан төсвийн [•] хувиас багагүй] байх;- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: [мөнгөн дүнгээр зааж өгөх/батлагдсан төсвийн [•] хувиас багагүй] байх;- Ашигтай ажилласан байх жилийн тоо: [жилийн тоог бич];

	<ul style="list-style-type: none"> - гадаадын этгээдийн санхүүгийн чадавхыг харуулах ТШЗ-ны 19.2-т заасан хугацааны санхүүгийн тайлангийн баталгаажсан хуулбар; - хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөргүй тухай харилцагч банкны мэдэгдэл; - Нэмэлтээр шаардах баримт бичиг... гэх мэт.]
ТШЗ 19.4.	Санхүүгийн тайландаа аудит хийлгэх хуулийн шаардлага бүхий тендерт оролцогчийг ТШЗ-ны 19.3-т заасан санхүүгийн тайлангийн хугацаанд хамаарах аудитын дүгнэлт ирүүлэхийг шаардах эсэх: [“шаардана” эсхүл “шаардахгүй” гэдгээс аль нэгийг сонгож бич]
ТШЗ 19.7.	Тендерт оролцогчийн техникийн чадавхи болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага: [Техникийн чадавхи болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг тогтоохдоо барааны онцлог, тоо хэмжээг харгалзан зайлшгүй шаардлагыг тусгах ба хувь хэмжээг нь үндэслэлгүйгээр хэт өндөр тогтоохгүй байна. Тавигдах шаардлагын жишээ нь дараах байж болох боловч үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Сүүлийн [●] жил буюу [●] оны аль нэгэнд ядаж нэг удаа төсөвт өртгийн [●] хувьтай тэнцүү ижил төстэй гэрээ байгуулж хүлээлгэж өгсөн байх. - Гэрээг гүйцэтгэхэд шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэлтэй байх; - Нэмэлтээр шаардах баримт бичиг... гэх мэт.]
ТШЗ 19.7.1.	Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: [“шаардана” эсхүл “шаардахгүй” гэдгээс аль нэгийг сонгож бич] [Хэрэв шаардах бол зөвшөөрөл олгодог байгууллага, тусгай зөвшөөрлийн нэрийг тодорхой бич]
ТШЗ 19.7.2.	Өөрөө үйлдвэрлээгүй барааг нийлүүлэх боломжтойг нотлох баримт: [“шаардана” эсхүл “шаардахгүй” гэдгээс аль нэгийг сонгож бич] [Хэрэв шаардах бол түүнд тавигдах шаардлагыг тодорхой бич]
ТШЗ 19.7.3.	Гэрээг хэрэгжүүлэх боловсон хүчний мэдээлэл: [“шаардана” эсхүл “шаардахгүй” гэдгээс аль нэгийг сонгож бич] [Хэрэв шаардах бол гэрээг хэрэгжүүлэх удирдах, хяналт тавих, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар, туршлагын талаар шаардах мэдээллийг тодорхой бич]
ТШЗ 19.7.4.	Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл: [“шаардана” эсхүл “шаардахгүй” гэдгээс аль нэгийг сонгож бич] [Хэрэв шаардах бол туршлагын мэдээлэл ирүүлэх сүүлийн 5 хүртэлх жилийн хугацаа болон туршлагыг нотлох баримт бичгийн төрлийг тодорхой заах]

ТШЗ 19.7.6.	Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: [“шаардана” эсхүл “шаардахгүй” гэдгээс аль нэгийг сонгож бич]
ТШЗ 19.7.7.	Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: [“шаардана” эсхүл “шаардахгүй” гэдгээс аль нэгийг сонгож бич] [Хэрэв шаардах бол бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлагыг тодорхой заах]
ТШЗ 20.4.	Барааны хувьд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад эд зүйлсийн жагсаалт ирүүлэх хугацаа: [Хугацааг тодорхой бич]
ТШЗ 20.7	Барааны чанарын баталгаа ирүүлэх эсэх: [“тийм” эсхүл “үгүй” гэдгээс аль нэгийг сонгож бич]. [тийм бол чанарын баталгааны дүн бич: гэрээний үнийн дүнгийн 5-10 хувь байхаар тусгах]
ТШЗ 21.5.	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: [“тохируулж болно” эсхүл “тохируулахгүй тогтмол байна” гэснээс аль тохирохыг бичнэ.]⁴ [Хэрэв гэрээний үнийг тохируулах бол үнэ тохируулах нөхцөл, аргачлалыг захиалагч тендер зарлахаас өмнө урьдчилан тогтоож, аргчлалыг энд тусгана.]
ТШЗ 21.7.	Захиалагч тодорхой багцын бараанаас хамгийн багадаа хэдэн хувийг нийлүүлэхээр санал болгож болох хувь хэмжээ: [Хувь бич]
ТШЗ 21.9.	Олон улсын худалдааны танхимын Incoterms-ийн хувилбар: [Жишээ нь:“Incoterms 2010, DDP”]. Бараа хүргэгдэх газар: [захиалагч барааг хүлээн авах агуулах, эсхүл уг бараа ашиглагдах газрын байршлыг бич]
ТШЗ 24.1	Тендерийн баталгаа: [“шаардана” эсхүл “шаардахгүй” гэж би] [Хэрэв тендерийн баталгаа шаардах бол тендерийн баталгааны дүнг төсөвт өртгийн 1 хувиар тооцож мөнгөн дүнгээр багц тус бүрээр доорх байдлаар заана: [Багц 1: [●] төгрөг Багц 2: [●] төгрөг]
ТШЗ 25.5.3	Бүлэг III-н маягтуудаас гадна ил болгох шаардлагатай гэж үзсэн бусад баримт бичиг байгаа эсэх: [“тийм” эсхүл “үгүй” гэдгээс аль нэгийг сонгож бич]

⁴ Захиалагч 2 жилээс дээш хугацаагаар хэрэгжих, эсхүл суурь үнэ огцом өөрчлөгдсөн нөхцөлд гэрээний үнэд тохируулга хийж болохоор хуулийн 40.4 дэх хэсэгт зохицуулсан.

	<p>[Хэрэв “тийм” гэж бичсэн бол нууцлахгүй ирүүлэх шаардлагатай баримт бичгийг доорх байдлаар жагсаан бич.</p> <p>1. ...</p> <p>2. ...]</p>
ТШЗ 26.1.	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: [он, сар, өдрийг бич]</p> <p>Цаг: [цаг, минутыг тодорхой бич]</p>
ТШЗ 28.1.	<p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг тендерт оролцогч цахим системээр дамжуулан авна.</p> <p>Огноо: [он, сар, өдрийг бич. Жишээ нь: 2020 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр]</p> <p>Цаг: [цаг, минутыг тодорхой бич. Жишээ нь: 16 цаг 00 минут г.м]</p> <p>Тендерт оролцогч, түүний төлөөлөгч болон сонирхсон бусад этгээд дараах газар ирж нээлтийн үйл ажиллагаатай танилцаж болох тендерийн нээлт хийх газрын хаяг: [аймаг/хот, сум/дүүрэг, гудамжны нэр, байшингийн дугаар, давхар, өрөөний дугаар]</p>
ТШЗ 32.1	<p>Үнэлгээнд харгалзах бусад шалгуур үзүүлэлт байгаа эсэх: [“тийм” эсхүл “үгүй” гэдгээс аль нэгийг сонгож бич].</p> <p>“Тийм” бол холбогдох шалгуур үзүүлэлийг тодорхой бич.</p>
ТШЗ 41.4	<p>Худалдан авах гэрээнд ашиглах жишиг гэрээний загварын нэр: [Жишиг гэрээний загварыг баталсан Сангийн сайдын тушаалын огноо, дугаар, гэрээний загварын нэр зэргийг бич]</p>
ТШЗ 43.4	<p>Бараа хүргэгдэх эцсийн цэг: [захиалагч бараа хүлээн авах агуулах, эсхүл уг бараа ашиглагдах газрын байршлыг бич]</p> <p>Бараа хүлээн авах хугацаа: [бараа хүлээн авах хугацааг бич. Жишээ нь: Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа: гэрээ байгуулснаас хойш [●] хоног. Бараа бүрэн хүлээлгэж өгсөн байх сүүлийн хугацаа: гэрээ байгуулснаас хойш [●] хоног.]</p>
ТШЗ 44.1	<p>Шалгарсан тендерт оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: [“тийм” эсхүл “үгүй” гэдгээс аль нэгийг сонгож бич].</p> <p>“Тийм” бол холбогдох жишиг загварын дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ.</p>
ТШЗ 45.1	<p>Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдаж байгаа эсэх: [“тийм” эсхүл “үгүй” гэдгээс аль нэгийг сонгож бич].</p> <p>“Тийм” бол “Урьдчилсан худалдан авах ажиллагааны журам”-ыг баримтлана.</p>

БҮЛЭГ III. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ

ТЕНДЕР ИЛГЭЭХ МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-д

1. Манай [тендерт оролцогчийн нэр] (цаашид “тендерт оролцогч” гэх) нь танай байгууллагаас баталсан тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэн [барааны нэр]-г [тендерийн үнийг тоогоор болон үсгээр бич]⁵ төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан хуваарийн дагуу нийлүүлэхээр санал (цаашид “тендер” гэх)-ыг хүргүүлж байна.
2. Тендерт оролцогч нь тендер шалгаруулалтын зааварчилгааны 4.2-т заасан нөхцөл байдал үүсээгүй болохыг баталж байгаа ба үүнтэй холбоотойгоор нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс тендерт оролцогчийн нэрийн өмнөөс гаргуулах бүрэн эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
3. Манай тендер шалгарсан тохиолдолд гэрээнд заасан барааг гэрээ байгуулснаас хойш [тоо] хоногийн дотор нийлүүлж үйлчилгээ үзүүлнэ. Энэ нь техникийн тодорхойлолтод заасан хуваарьт үндэслэнэ.
4. Бидний санал болгож байгаа тендер шалгарсан тохиолдолд дараах үнийн хөнгөлөлт [“үзүүлнэ” эсхүл “үзүүлэхгүй” гэдгийн аль нэгийг бич] [Үнийн хөнгөлөлт үзүүлэхээр бол техникийн тодорхойлолтонд дурдсан барааны аль хэсэг, нэр төрөлд эсхүл бүхэлд нь ямар хөнгөлөлт үзүүлэх саналтай байгаа, үнийн хөнгөлөлт тооцох аргачлалыг хэрхэн хэрэглэх талаарх саналаа бич] үзүүлнэ.
5. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш [30-аас доошгүй хоногийг бич] хоногийн хугацаанд хүчинтэй байна.
[5.Тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдаж байгаа тул бидний хүргүүлж буй энэхүү тендер нь тендерийн баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна.]⁶
6. Бид захиалагчийн баталсан тендерийн баримт бичиг, түүгээр тогтоосон нөхцөл шаардлага, гэрээний загварыг бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцож байна.
7. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцлийг бүрдүүлнэ.
8. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр:

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн гарын үсэг, байгууллагын тэмдэг]:

Албан тушаал, нэр:

Хаяг:

⁵ Үнийн хөнгөлөлтийг тооцоогүй тухайн тендерийн нийт үнийг бичнэ.

⁶ Тендер шалгаруулалтыг урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулж байгаа бол 5 дугаар өгүүлбэрийг үүгээр солино.

БАРААНЫ ҮНИЙН ХУВААРЬ

1	2	3	4	5	6	7	8	9	10
Нэр төрөл	Барааны тодорхойлолт	Гарал үүслийн улс	Тоо ширхэг болон эд анги	Нэгж үнэ	Нэр төрөл бүрийн бүгд үнэ (4x5)	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ	Гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд төлөх НӨТ болон бусад татвар хураамж	Нэр төрөл бүрийн нийт үнэ (6+7+8)	Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх ⁷
									Тийм/Үгүй
Тендерийн нийт үнэ (10)									

Тендерт оролцогчийн нэр _____ Гарын үсэг, тэмдэг/тамга _____ Огноо _____

⁷ Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх гэдэгт "тийм" гэж бөглөсөн бол түүнийг нотлох баримт бичгийг хавсаргана.

ТЕНДЕРИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ
(БАНКНЫ БАТАЛГАА)

Баталгаа хүлээн авагч: [Захиалагч байгууллагын нэр, хаягийг бичнэ үү]

Огноо: [баталгаа гаргасан огноог бичнэ үү]

Гүйцэтгэлийн баталгааны дугаар: [Тендерийн баталгааны дугаар бичнэ үү]

Баталгаа гаргагч: [хэвлэмэл хуудсанд бичигдээгүй бол баталгаа гаргагч байгууллагын нэр, хаягийг бичнэ үү]

1. Баталгаа гаргагч нь **[Тендерт оролцогчийн нэр]** (цаашид “Тендерт оролцогч” гэх)-ийг **[Тендер шалгаруулалтын нэр]** барааны тендер (цаашид “Тендер” гэх) санал болгосонтой холбогдуулан Баталгаа хүлээн авагчийн өмнө нийт **[мөнгөн дүн]**-ийн⁸ төлбөрийн үүрэг хүлээж баталгаа гаргаж байна.
2. Төлбөр төлөх үүрэг нь дор дурдсан нөхцөлд үүснэ. Үүнд:
 - 2.1. Тендерийг нээсний дараа, өөрийн хүргүүлсэн тендерийн хүчинтэй байх хугацаа (тендерт оролцогчийн албан бичгээр сунгасан хугацааг оролцуулан цаашид “**Тендер хүчинтэй байх хугацаа**” гэх) дуусахаас өмнө тендерт оролцогч нь тухайн тендерээс бүхэлд нь эсхүл хэсэгчлэн татгалзсанаа бичгээр мэдэгдсэн;
 - 2.2. Захиалагч Тендер хүчинтэй байх хугацаанд багтаж гэрээ байгуулах эрх олгосон үед тендерт оролцогч:
 - 2.2.1. тендерийн баримт бичигт заасны дагуу гэрээг баталгаажуулж ирүүлээгүй;
 - 2.2.2. тендерийн баримт бичигт заасны дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй;
 - 2.2.3. тендерийн баримт бичигт заасны дагуу хийгдсэн тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй, эсхүл зөвшөөрсөн эсэх тухай хариуг бичгээр ирүүлээгүй.
 - 2.3. Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тендерт оролцогчийн гаргасан гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.
3. Дээр тодорхойлсон нөхцөлүүдийн аль нэг нь үүссэнийг дурдаж төлбөр төлүүлэх тухай захиалагчийн анхны шаардлагыг хүлээн авсан даруйд Баталгаа гаргагч нь төлбөрийг тус мэдэгдэлд заасан Монгол Улсын Сангийн яамны дансанд шилжүүлнэ. Баталгаа гаргагчаас төлүүлэх шаардлагын хэмжээ нь 1-т заасан мөнгөн дүнгээс хэтрэхгүй ба 2.3-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд 20 сая хүртэл төгрөг эсхүл түүнтэй тэнцэх гадаад валютаас хэтрэхгүй байна.
4. Энэхүү баталгаа нь дараах хугацаанд хүчинтэй байна:
 - 4.1. Тендерт оролцогчийн тендер шалгарсан тохиолдолд Тендерт оролцогч нь Захиалагчтай гэрээ байгуулж, холбогдох гүйцэтгэлийн баталгааг Захиалагчид хүргүүлсэн тухай мэдэгдлийг Захиалагчаас хүлээн авах хүртэл;
 - 4.2. Тендерт оролцогчийн тендер шалгараагүй тохиолдолд түүний хүргүүлсэн тендерийн хүчинтэй хугацаа дууссанаас хойш 28 дахь хоногийг дуустал, эсхүл энэ хугацаанаас өмнө захиалагч бусад этгээдтэй гэрээ байгуулсан үндэслэлээр Тендерт оролцогчийн тендерийн баталгааг хүчингүй болгохыг зөвшөөрсөн мэдэгдлийг Захиалагчаас хүлээн авах хүртэл хугацаанд.
5. Иймд энэхүү баталгааны дагуу гаргах аливаа шаардлагыг 4-т заасан хугацаанд багтаж Баталгаа гаргагч талд мэдэгдэх ёстой.

⁸ Баталгааны дүнг тендерийн, эсхүл захиалагч хүлээн зөвшөөрөх чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлж, үсгээр болон тоогоор заана. Энэ дүн нь ТШЗ-ны 21.1-д заасантай ижил байна.

6. Энэхүү баталгааг дээр дурдсанаас бусад үндэслэлээр хүчингүй болгосноос үүдэн гарах эрсдэлийг Баталгаа гаргагч этгээд хариуцна.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга:

Огноо:

Хаяг:

Маягт №3Б

(ЗАСГИЙН ГАЗРЫН БОНДЫН БОЛОН ЗАСГИЙН ГАЗРААС ЗӨВШӨӨРСӨН ҮНЭТ ЦААСНЫ БАТАЛГАА)

Баталгаа хүлээн авагч: [Захиалагч байгууллагын нэр, хаягийг бичнэ үү]

Огноо: [баталгаа гаргасан огноог бичнэ үү]

Гүйцэтгэлийн баталгааны дугаар: [Тендерийн баталгааны дугаар бичнэ үү]

Баталгаа гаргагч: [хэвлэмэл хуудсанд бичигдээгүй бол баталгаа гаргагч байгууллагын нэр, хаягийг бичнэ үү]

1. Баталгаа гаргагч нь **[Тендерт оролцогчийн нэр]** (цаашид “Тендерт оролцогч” гэх)-ийг **[Тендер шалгаруулалтын нэр]** барааны тендер (цаашид “Тендер” гэх) санал болгосонтой холбогдуулан Баталгаа хүлээн авагчийн өмнө нийт **[мөнгөн дүн]**-ийн⁹ төлбөрийн үүрэг хүлээж **[баталгааны дүн тоогоор]** **[дүн үсгээр]** нэрлэсэн үнэ бүхий **[Засгийн газрын бонд эсхүл үнэт цаасны нэр]** (цаашид “Үнэт цаас” гэх)-г¹⁰ үндэслэн баталгаа гаргаж байна.
2. Үнэт цаасыг шилжүүлэх үүрэг нь дор дурдсан нөхцөлд үүснэ. Үүнд:
 - 2.1. Тендерийг нээсний дараа, өөрийн хүргүүлсэн тендерийн хүчинтэй байх хугацаа (тендерт оролцогчийн албан бичгээр сунгасан хугацааг оролцуулан цаашид “**Тендер хүчинтэй байх хугацаа**” гэх) дуусахаас өмнө тендерт оролцогч нь тухайн тендерээс бүхэлд нь эсхүл хэсэгчлэн татгалзсанаа бичгээр мэдэгдсэн;
 - 2.2. Захиалагч Тендер хүчинтэй байх хугацаанд багтаж гэрээ байгуулах эрх олгосон үед тендерт оролцогч:
 - 2.2.1. тендерийн баримт бичигт заасны дагуу гэрээг баталгаажуулж ирүүлээгүй;
 - 2.2.2. тендерийн баримт бичигт заасны дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй;
 - 2.2.3. тендерийн баримт бичигт заасны дагуу хийгдсэн тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй, эсхүл хүлээн зөвшөөрсөн эсэх тухай хариуг бичгээр ирүүлээгүй.
 - 2.3. Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тендерт оролцогчийн гаргасан гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.
3. Дээр тодорхойлсон нөхцөлүүдийн аль нэг нь үүссэнийг дурдаж Үнэт цаасыг шилжүүлэх тухай захиалагчийн анхны шаардлагыг хүлээн авсан даруйд Баталгаа гаргагч нь Үнэт цаасыг Монгол Улсын Сангийн яамны нэр дээр шилжүүлнэ. Баталгаа гаргагчаас шилжүүлэх Үнэт цаасны нэрлэсэн үнийн дүн нь 1-т заасан мөнгөн дүнгээс хэтрэхгүй ба 2.3-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд 20 сая хүртэл төгрөг эсхүл түүнтэй тэнцэх гадаад валютаас хэтрэхгүй байна.
4. Энэхүү баталгаа нь дараах хугацаанд хүчинтэй байна:
 - 4.1. Тендерт оролцогчийн тендер шалгарсан тохиолдолд Тендерт оролцогч нь Захиалагчтай гэрээ байгуулж, холбогдох гүйцэтгэлийн баталгааг Захиалагчид хүргүүлсэн тухай мэдэгдлийг Захиалагчаас хүлээн авах хүртэл;
 - 4.2. Тендерт оролцогчийн тендер шалгараагүй тохиолдолд түүний хүргүүлсэн тендерийн хүчинтэй хугацаа дууссанаас хойш 28 дахь хоногийг дуустал, эсхүл энэ хугацаанаас өмнө түүний тендерийн баталгааг хүчингүй болгохыг зөвшөөрсөн мэдэгдлийг Захиалагчаас хүлээн авах хүртэл хугацаанд.
5. Иймд энэхүү баталгааны дагуу гаргах аливаа шаардлагыг 4-т заасан хугацаанд багтаж Баталгаа гаргагч талд мэдэгдэх ёстой.

⁹ Баталгааны дүнг тендерийн, эсхүл захиалагч хүлээн зөвшөөрөх чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлж, үсгээр болон тоогоор заана. Энэ дүн нь ТШЗ-ны 21.1-д заасантай ижил байна.

¹⁰ Засгийн газрын бонд болон үнэт цаасны эргэн төлөгдөх хугацаа нь тендер нээх өдрөөс хойш 3-аас доошгүй сарын дараа байна.

6. Энэхүү баталгааг дээр дурдсанаас бусад үндэслэлээр хүчингүй болгосноос үүдэн гарах эрсдэлийг баталгаа гаргагч этгээд хариуцна.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Биржийн эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Биржийн тамга

Огноо:

Хаяг:

Маягт №4

Хамтран ажиллах түншлэл болон туслан гүйцэтгэгчийн мэдээлэл

	Түншлэл/Туслан гүйцэтгэгчийн нэр	Тус тендерт санал болгож байгаа чиг үүрэг	Нийт гэрээнд эзлэх хийх ажлын дүн /төгрөг/	...
Түншлэлийн мэдээлэл				
Туслан гүйцэтгэгчийн мэдээлэл				

Ижил төстэй гэрээ гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл¹¹

Төсөл, арга хэмжээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхлэх, дуусах/	Одоо үргэлжилж буй гэрээний хувьд дуусах хугацааг бичих

¹¹ Одоо үргэлжилж байгаа гэрээний мэдээллийг хамт ирүүлнэ

Ижил төстэй гэрээ гүйцэтгэсэн туршлага¹²*/Уг маягтыг бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө/*

Тендерт оролцогч / түншлэлийн нэр:

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Сунгасан эсэх
7.	Гэрээний дүн
8.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч
9.	Хавсралт <ul style="list-style-type: none">- Гэрээний хуулбар- Гэрээ дүгнэсэн акт- Захиалагчийн тодорхойлолт

¹² Тендерт оролцогч, түншлэл тус бүрдээ уг маягтыг бөглөнө.

Санхүүгийн чадавхийн мэдээлэл

[Тендерт оролцогч / түншлэлийн нэр]

1. Харилцагч банкны мэдээлэл:

Банкны нэр	Дансны үлдэгдэл	Хугацаа хэтэрсэн өртэй эсэх

2. Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

2.1. Борлуулалтын орлогын чадавхийн үзүүлэлт:

/сая төгрөг/

борлуулалтын орлого	[Түншлэлийг төлөөлөх эрх бүхий этгээд]	[Түншлэлийн гишүүн n]
	... ХХК	... ХХК
[ОН] ¹³		
[ОН]		
[ОН]		

2.2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн чадавхийн үзүүлэлт

/сая төгрөг/

		[Түншлэлийг төлөөлөх эрх бүхий этгээд]	[Түншлэлийн гишүүн n]
		... ХХК	... ХХК
Санхүүгийн тайлан дээрх түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө		
	Дансны авлага		
	Нийт		

¹³ Захиалагчийн ТӨХ-д заасан хугацаагаар уг мэдээллийг ирүүлнэ.

Банкны тодорхойлолт	Зээл олгох боломжтой хэмжээ /банкны албан бичгийг хавсаргах/		
------------------------	--	--	--

2.3. Ашигтай ажилласан байх чадавхийн үзүүлэлт

/сая төгрөг/

Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	[Түншлэлийг төлөөлөх эрх бүхий этгээд]	[Түншлэлийн гишүүн n]
	... ХХК	... ХХК
[ОН] ¹⁴		
[ОН]		
[ОН]		

¹⁴ Захиалагчийн ТӨХ-д заасан хугацаагаар уг мэдээллийг ирүүлнэ.

Ажиллах хүчний чадавхийн мэдээлэл

Тухайн бараа нийлүүлж, угсарч суурилуулахад шаардлагатай, захиалагч ТӨХ-д шаардсан тохиолдолд тендерт оролцогч (мөн туслан гүйцэтгэгч) уг мэдээллийг ирүүлнэ.

Тухайн тендерт санал болгож байгаа боловсон хүчний мэдээлэл¹⁵

Тендерт гүйцэтгэх үүрэг	Овог, нэр	Ажилласан жилийн туршлага	Тухайн байгууллагын үндсэн ажилтан, ажилласан жил	...

¹⁵ Уг ажиллах хүчин бусад төсөлд давхцаагүй байх ёстой.

БҮЛЭГ IV. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү санамж нь захиалагчид мэдээлэл өгч туслах зорилготой бөгөөд түүнийг тендерийн баримт бичгийг боловсруулж дуусахад хасна.

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай байгаа барааны техникийн тодорхойлолтыг нарийвчлан тодорхойлоход оршдог.

Ойлгомжтой бөгөөд сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд тендерт оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно. Техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ өрсөлдөөнийг аль болох өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд үүний зэрэгцээ худалдан авах барааны шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд л худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийг үнэлэх үнэлгээ зөв явагдана.

Гэрээнд өөрөөр заагаагүй бол бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, орчин үеийн загварын, мөн зураг төсөл, материалын хувьд сүүлийн үеийн хандлагыг хангасан байх нөхцөлийг техникийн тодорхойлолтод шаардвал зохино.

Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай. Техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ метрийн системийг ашиглана. Бүх салбарт хэрэглэж болох нийтлэг жишиг техникийн тодорхойлолт гэж байхгүй. Бүх төрлийн барааны стандарт буюу ерөнхий техникийн тодорхойлолт боловсруулж стандартчилах нь чухал ач холбогдолтой. Энэ стандарт техникийн тодорхойлолтыг тухайн бараанд нийцүүлэн, зохих өөрчлөлт оруулах замаар ашиглана.

Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Бараа материалын, техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.

Жишиг заалт: Стандарт болон кодын дүйцэх байдал

Гэрээнд өөрөөр заагаагүй бол техникийн тодорхойлолтод дурдсан нийлүүлэгдэх бараа, материал, тэдгээрийг турших стандарт, кодыг уг стандарт буюу кодын тухайн үед мөрдөгдөж буй хувилбарт тодорхойлсноор хэрэглэнэ. Үндэсний стандарт, кодыг заасан тохиолдолд түүнтэй дүйцэх, эсхүл түүнээс илүү чанартай олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн бусад стандарт, кодыг хүлээн зөвшөөрнө.

Барааны тэмдэг, каталогийн дугаарыг заасан шаардлагыг аль болох тавихгүй байна. Зайлшгүй шаардлагын улмаас эдгээрийг хэрэглэх бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэж нэмж заана.

Шаардлагатай тохиолдолд захиалагч зураг болон ажлын талбайн төлөвлөгөөг тендерийн баримт бичгийн хамт тендерт оролцогчдод өгнө. Үүнд мөн тендерт оролцогч зураг болон загварыг тендертэй хамт, эсхүл гэрээний хэрэгжилтийн явцад захиалагчид урьдчилан хянуулах зорилгоор ирүүлэхээр зааж болно.

Техникийн тодорхойлолт боловсруулахдаа эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх.

Захиалагч шаардлагатай бол нийлүүлэгдэх барааны хувьд хийгдсэн байх ёстой үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилтын жагсаалтыг холбогдох мэдээллийн хамт ирүүлэхийг тендерт оролцогчоос шаардаж болно.

Тендерт оролцогч тендерийн баримт бичгийн ТШЗ-ны 19 дүгээр зүйлд заасан нотлох баримтыг заавал ирүүлэх ёстой бөгөөд дараах нотлох баримтыг мөн тендерт ирүүлнэ. Үүнд:

- 1.
- 2.

[шаардлагатай баримт бичгүүдийг жагсааж бичих]

Нийлүүлэх бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

<i>Нэр төрлийн дугаар</i>	<i>Барааны нэр</i>	<i>Техникийн тодорхойлолт болон стандарт</i>

Эм, эмнэлгийн хэрэгслийн жишиг техникийн тодорхойлолт

- 1. Бүтээгдэхүүн ий болон баглаа боодлын тодорхойлолт**
- 1.1. Тендерийн урилгын дагуу захиалагчийн худалдан авах эм нь эмийн улсын бүртгэлд бүртгэгдсэн, эмнэлгийн хэрэгсэл нь зайлшгүй шаардлагатай эмнэлгийн хэрэгслийн жагсаалтад орсон байна.
- 1.2. Савлагаа, шошгын стандарт нь ДЭМБ-ийн эм үйлдвэрлэлийн зохион байгуулалт, хяналтын дүрэм (GMP)-ийн хамгийн сүүлийн шаардлагуудыг бүрэн хангасан байна. Мансууруулах, сэтгэц нөлөөт эмийг нийлүүлэх тендерт оролцогч түүнийг импортлох тусгай зөвшөөрөл авсан байна.
- 1.3. Бүтээгдэхүүний тодорхойлолтод эмийн хэлбэр /шахмал, тарил/уусмал болон нунтаг, тосон түрхлэг гэх мэт/ болон найрлага, тун хэмжээ /олон улсын нэгж {IU}, мг, процент)-г заана.
- 1.4. Эм, эмнэлгийн хэрэгсэл болон түүний савлалт, хаяглалтын материал нь (шил, хуванцар сав гэх мэт) тээвэрлэлтийн явц, хадгалалтын үеийн шаардлага, түүнчлэн Монгол орны цаг агаарын нөхцөлд тохирсон байна. Бүх савлагаа нь Монгол Улсын холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажсан эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх, савлах стандартыг хангаж дахин савлах боломжгүйгээр битүүмжлэгдсэн байна. Захиалагч аливаа нэмэлт шаардлагыг тусгайлан тайлбарласан байна.
- 1.5. Шошго болон хэрэглэх заавар нь захиалагчийн тусгайлан заасан хэл дээр байна.
- 1.6. Хөлдөөх эсхүл тодорхой хэмийг тогтвортой байлгах зэрэг хадгалалтын тусгай горим шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийн шошго болон сав, баглаа боодолд үүнийг тусгайлан зааж тээвэрлэлтийн явцад мөрдөнө.
- 1.7. Гэрээ байгуулах эрх авсан этгээд захиалагч шаардсан тохиолдолд тухайн бүтээгдэхүүний тайлбар зааварчилгааг тендерийн хэл дээр хөрвүүлнэ.
- 2. Хаяглах заавар**
- 2.1. Эм, эмнэлгийн хэрэгслийн үндсэн савлагаа дээрх шошго нь GMP стандартыг хангасан байх бөгөөд дараах мэдээллийг агуулсан байна:
- 2.1.1. Олон улсын нэр (INN) болон худалдааны нэрийн дээр байнга бичигдэх ерөнхий нэршлийг бичсэн байна. Худалдааны нэр нь ерөнхий нэршлээс илүү тод ба том бичигдэх ёсгүй;
- 2.1.2. Эмийн хэлбэр (шахмал, тарил/уусмал...);
- 2.1.3. үндсэн үйлчлэгч бодис, түүний нэгж тун дахь хэмжээ;
- 2.1.4. зохих фармакопейн стандарт;
- 2.1.5. захиалагч шаардлагатай гэж үзвэл захиалагчийн тэмдэг, код, бүртгэлийн дугаар;
- 2.1.6. баглаа бүр дэх бүтээгдэхүүний орц хэмжээ;
- 2.1.7. хэрэглэх заавар;
- 2.1.8. хадгалалтын онцгой нөхцөл /шаардлага;
- 2.1.9. цувралын дугаар;
- 2.1.10. үйлдвэрлэсэн огноо болон хүчинтэй байх хугацаа (кодоор бус үсгээр тодорхой бичих);
- 2.1.11. үйлдвэрийн нэр ба хаяг;

- 2.1.12. бусад шаардлагатай сануулга.
- 2.2. Гаднах савлагааны дээр дээрх мэдээллийг мөн тэмдэглэсэн байна.
- 3. Сав, баглаа боодлын таних тэмдэг**
- 3.1. Бүх баглаа боодолд доорх мэдээллийг тусгана:
- 3.1.1. захиалагчийн бүртгэлийн дугаар;
- 3.1.2. эмийн ерөнхий нэршил;
- 3.1.3. эмийн хэлбэр (шахмал, тарил/уусмал...);
- 3.1.4. үйлдвэрлэсэн огноо болон хүчинтэй байх хугацаа (кодоор бус үсгээр тодорхой бичих);
- 3.1.5. цувралын дугаар;
- 3.1.6. нэгж боодол дахь тоо хэмжээ;
- 3.1.7. хадгалалтын тусгай заавар;
- 3.1.8. үйлдвэрийн нэр ба хаяг;
- 3.1.9. бусад шаардлагатай мэдээлэл.
- 3.2. Боодол бүр нь нэгээс илүүгүй бүтээгдэхүүний цувралыг агуулсан байна.
- 4. Онцлог таних тэмдэг**
- 4.1. Захиалагч нь нийлүүлж буй бүтээгдэхүүний сав баглаа боодол, хаягт өөрийн таних тэмдгийг тусгуулах шаардлагыг техникийн тодорхойлолтод тусгах замаар нийлүүлэгчид тавьж болно. Түүний загвар болон дэлгэрэнгүй тайлбарыг захиалагч тендер шалгаруулалтын өмнө бэлэн болгосон байх бөгөөд гэрээ байгуулах эрх олгох үед эцэслэн баталгаажуулж нийлүүлэгчид өгнө.
- 5. Барааны чанарын баталгааны стандарт**
- 5.1. Шалгарсан тендерт оролцогч шаардсан тохиолдолд захиалагчид дараах мэдээлэл, баримт бичгийг ирүүлнэ:
- 5.1.1. нийлүүлэгдэж буй бараанд хамаарах эмийн нэр төрөл бүрийн тоо хэмжээ, химийн шинжилгээ, ариун чанар, халууруулах чанар, хоруу чанарын болон бусад шинжилгээний талаар ДЭМБ-ын жишиг цувралын болон бүтээгдэхүүний сертификат;
- 5.1.2. аль нэг эсхүл бүх шинжилгээний аргачлал (GMP эсхүл ISO);
- 5.1.3. аль нэгэн онцгойлсон эмийн био-хүртээмж болон/эсхүл био-эквивалентын нотолгоо; Энэ мэдээллийг зөвхөн хатуу нууцлалын доор ирүүлнэ.
- 5.1.4. худалдаанд зориулсан савлалттай холбогдуулж хүчинтэй байх хугацаа дуусах огноо болон тогтвортой чанарыг илэрхийлсэн бусад үзүүлэлтийг тодорхойлсон үндэслэл;
- 5.1.5. барааны дээж.
- 5.2. Шалгарсан тендерт оролцогч нь захиалагч шаардсан тохиолдолд үйлдвэрлэлт нь GMP-ийн хадгалалтын шаардлагууд болон чанарын хяналтын механизмд нийцэж буй эсэхтэй танилцуулах

зорилгоор түүнийг үйлдвэрлэлийн болон агуулахын байранд нэвтрэх боломжоор хангана.

**6. Эм,
эмнэлгийн
хэрэгслийг
багцлах**

- 6.1. Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагааны хувьд салбарын онцлог шинж чанараас шалтгаалан зөвхөн бүтээгдэхүүний нэр төрөлд үндэслэсэн стандарт ангиллыг ашиглаж бүтээгдэхүүний багцыг өрсөлдөөнийг хангахуйцаар оновчтой тодорхойлоход хүндрэлтэй байдаг. Тиймээс эмүүдийг фармакологийн буюу өвчний ангиллаар, эмнэлгийн хэрэгслийг тухайн бараа хэрэглэгдэх нарийн мэргэжлийн тусламжийн төрлөөр багцалж болно. Мөн ижил нэр төрлийн бүтээгдэхүүнийг тэдгээрийг хадгалах хугацаа, хэрэглэх хэмжээ зэргийг сайтар харгалзан багцалж болно. Зайлшгүй шаардлагатай эм худалдан авах ажиллагаанд ашиглаж болох багцын загварыг хавсралтад үзүүлээ. Багц нь аль болох жижиг байх нь зохимжтой.
- 6.2. Эмнэлгийн хэрэгслийг багцлахдаа Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан зайлшгүй шаардлагатай эмнэлгийн хэрэгслийн жагсаалтыг үндэслэн дараах ангиллыг ашиглана. Үүнд:
 - 6.2.1. Ороох боох материал
 - 6.2.2. Тариур зүү, мэс заслын хутга
 - 6.2.3. Оёдлын материал
 - 6.2.4. Хамгаалалтын хувцас
 - 6.2.5. Катетер, гуурс
 - 6.2.6. Рентген
 - 6.2.7. Унтуулгын хэрэгсэл
 - 6.2.8. Хэт авианы хэрэгсэл
 - 6.2.9. Шүд, эрүү нүүрний хэрэгсэл
 - 6.2.10. Нүдний хэрэгсэл
 - 6.2.11. Чих хамар хоолойн хэрэгсэл
 - 6.2.12. Уламжлалт анагаах ухаан
 - 6.2.13. Эх барих, эмэгтэйчүүдийн хэрэгсэл
 - 6.2.14. Бусад.
- 6.3. Нэг төрлийн эм, эмнэлгийн хэрэгслийг илэрхийлэхэд олон тооны худалдааны нэр болон барааны тэмдгүүд хэрэглэгддэг учир тендер шалгаруулалтын багцыг хийхдээ тухайн эмийн олон улсын нэршлийг ашиглах нь зүйтэй.
- 6.4. Энэ нь мөн өрсөлдөөнийг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй. Тендерт оролцогч нь техникийн тодорхойлолтыг хангасан эм, эмнэлгийн хэрэгслийг худалдааны нэрээр ирүүлж шалгарсан тохиолдолд захиалагч тендерт оролцогчоос худалдааны нэрийн дээд талд том үсгээр, илүү тодоор олон улсын нэршил буюу ерөнхий нэрийг бүх хаяглалт дээр харуулахыг шаардах хэрэгтэй.

7. Нийлүүлэлтийн шаардлагын хуваарь бэлтгэх
- 7.1. Нийлүүлэлтийн шаардлагын хуваарьт бараа тус бүрийн хувьд нийлүүлэгдсэн байх хугацаа болон тухайн нэр төрлийн онцлогийг харуулсан техникийн тодорхойлолттой уялдсан товч тайлбар, тоо хэмжээг оруулна.
- 7.2. Нийлүүлэлтийн шаардлагын хуваарьт эм, эмнэлгийн хэрэгслийн олон улсын нэршил /INN/ эсхүл ерөнхий нэр (холимог эмийн хувьд оролцсон бодис тус бүрийн нэр), бодис тус бүрийн тун (метрийн нэгжээр), нэгж эмийн хэлбэр (шахмал, капсул, тарил/уусмал г.м), боодлын хэмжээ болон тоо ширхэгийг тусгана.
- 7.3. Зарим тохиолдолд нийлүүлэгч нэгж эмийн тоо ижил боловч боодлын хэмжээ өөр бараа санал болгоход харилцан үл ойлголцлоос сэргийлж нийлүүлэлтийн шаардлагын хуваарьт нэгж болон боодлын нийт дүнг тус бүрт нь шаардаж болно. Нийлүүлэлтийн шаардлагын хуваарьт дурдсан боодлын хэмжээг өөрөөр санал болгох боломжтой эсэхийг тусгайлан заах шаардлагатай.
- Нийлүүлэлтийн хуваарьт гэрээ байгуулагдсан өдрөөс хойшхи 7 хоногоор хэмжсэн хугацааг заах ба энэ нь бараа нийлүүлэгдсэн байх хугацааг харуулах ба энэ нь EXW нөхцөлийн хувьд захиалагчийн агуулах эсхүл CIP нөхцөлийн хувьд заасан газар хүртлэх хугацаа байна.

Зураг, төсөл

Барааны эскиж, зураг, төсөл хавсаргах шаардлагатай бол дараах хүснэгтийг ашиглана.

Зураг төслийн жагсаалт		
Зураг, төслийн дугаар	Зураг төслийн нэр	Зориулалт

Шалгалт, туршилт

Захиалагч шаардлагатай бол нийлүүлэгдэх барааны хувьд хийгдсэн байх ёстой үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилтын жагсаалтыг холбогдох мэдээллийн хамт ирүүлэхийг тендерт оролцогчоос шаардаж болно.